

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-34

1.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны тайлан	4-34
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 3 дугаар сарын 31-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 27 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 38 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, С.Амарсайхан, М.Нарантуяа-Нара,
Л.Мөнхбаатар, У.Отгонбаяр, Л.Соронзонболд, С.Эрдэнэболд;
Тасалсан: Х.Баттулга.

Нэг.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Г.Эрдэнэбат, мөн газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх Б.Алтантуяа, референт Т.Гоцбаяр, Г.Нямдэлгэр, Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, мөн Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс, мөн хэлтсийн референт Б.Дэлгэрмаа, Н.Манлайбаатар, Г.Дэлгэрбаяр, ахлах мэргэжилтэн Э.Сүлдбаяр, Б.Ивээл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Б.Тулга, Х.Баасанжаргал, Ц.Сандаг-Очир, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Д.Эрдэнэбат, Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Х.Тэмүүжин, С.Одонтуяа, Б.Баярмаа, Д.Ганбат, Л.Соронзонболд, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны тайланг сонсов.

Уг асуудлыг 12 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 50 минут үргэлжилж, 27 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр 12 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 10 цаг 38 минут

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Цогтбаатар: Хууль зүйн байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг дэвшүүлье ээ. Ингээд байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн далдугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдааны ирц Дамдины Цогтбаатар, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Энхбаярын Батшугар, Баярмагнайн Баярбаатар, Борхүүгийн Дэлгэрсайхан, Гонгорын Дамдинням, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Даваахүүгийн Пүрэвдаваа, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Буяагийн Тулгаа, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар гэсэн ирцтэйгээр 59.3 хувийн ирцтэйгээр манай ирцийн шаардлага хангагдсан байна аа. Ингээд хуралдааны ирцийг танилцууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр нэг асуудал байгаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны тайлан. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байвал нэрсээ өгье. Алга байна. Тэгвэл хэлэлцэх асуудалдаа оръё.

[ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны тайланг хэлэлцье.](#)

Ажлын хэсэг байна уу? Би энд ингээд танилцуулгатай холбогдон ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны тайланг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхэд оролцох албан тушаалтнуудын нэрсийг би танилцуулъя аа. Я.Цэлмэн ХЭҮК-ын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Ш.Үнэнтөгс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Б.Дэлгэрмаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн референт, Н.Манлайбаатар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн референт, Г.Дэлгэрбаяр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн сурталчилгаа хариуцсан референт, Э.Сүлдбаяр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, Б.Ивээл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн ийм ирцтэйгээр ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг байна. Улсын Их Хурлаас бас Тамгын газраас дараах албан тушаалтнууд орж байгаа. Г.Эрдэнэбат Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга, Б.Алтантуяа Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн

хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх, Т.Гоцбаяр Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын референт, Г.Нямдэлгэр Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын референт гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр Их Хурлын бас Тамгын газраас хүмүүс ажлын хэсэгт орсон байгаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны тайланг ХЭҮК-ын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Цэлмэн танилцуулна аа.

Цэлмэн даргын микрофоныг өгье 3 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны эрхэм дарга, эрхэм Их Хурлын гишүүд ээ,

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэн мэндчилье. Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 7 дугаар бүлэгт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан. Хуулийн 31.4 дэх хэсэгт заасны дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд танилцуулж хэвлэн нийтэлнэ гэж заасан. Энэ хуулийн үндэслэлийн дагуу 2025 оны тайлангаа боловсруулан танилцуулж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд тайланг бол 2025 оны 1 сарын 1-ээс 12 сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажил. Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, сургалт, сурталчилгаа, дүн шинжилгээ, албан ёсны, статистик мэдээлэл төрийн байгууллага албан тушаалтнуудад хүргүүлсэн зөвлөмж, биелэлт, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлт, эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, саатуулах, ялгаварлан гадуурхах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ болон олон улсын байгууллагуудын дүгнэлт үндэслэн 8 бүлэг саналын хамт боловсруулан Хууль зүйн байнгын хорооны даргад 2025 оны 3 сарын 20-нд өргөн барьж Их Хурлын гишүүдэд хүргүүлсэн.

Мөн ди парламентад байршуулан олон нийтэд танилцуулах арга хэмжээг Хууль зүйн байнгын хорооноос авч байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг боловсруулахдаа Улсын Их Хурлын Тамгын газраас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланд хийсэн хяналт, шинжилгээний дүгнэлт, зөвлөмжид дурдагдсан асуудлуудыг анхаарч хүний эрхийг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан саналыг хүндэтгэн хэрэгжүүлж ажиллалаа.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 34.1.11-д заасан бүрэн эрхийн дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг баталж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд 2025 оны тайланг боловсруулахдаа 2022-2024 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тоон мэдээлэлтэй харьцуулж тайлагнаж байна. Үндэсний ажиллагааны хүрээнд ХЗБХ, Хүний эрхийн дэд хороо олон улсын болон төрийн бус иргэний нийгмийн холбогдох байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулах, хамтарсан төлөвлөгөө батлан дэвшүүлсэн зорилтын хүрээнд үр дүнтэй хамтран ажилласан нь бодит үр дүн

дээшлэхэд нөлөөллөө. 2022-2025 онуудад үндэсний ажиллагаанаас нийт 193 байршилд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийж 96 удаагийн зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлээ.

2025 оны буюу тайлант хугацаанд бол нийт 65 байршилд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ хийсэн. Үүнд хорих байгууллага, цагдан хорих байр, баривчлах байр, цагдаагийн эрүүлжүүлэх саатуулах байр, СЭМҮТ хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны асрамжийн газар, цэргийн сахилгын байр, сургуулийн дотуур байр зэрэг байгууллагуудыг хамрууллаа. Хяналт шинжилгээний явцад тогтоогдсон эрсдэлийн нөхцөл байдлыг үндэслэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 474 заалт бүхий 51 зөвлөмжийг байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлж, хяналт 50 ажилласан. Нийт одоо биелэлтийн дүн 85 хувьтайгаар үнэлэгдсэн байгаа. Зөвлөмжийн мөрөөр дээрх байгууллагууд бол хүний эрхийг хангах хамгаалах ялангуяа эрүү шүүлт хүнлэг бус харьцаа доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой хөрөнгө мөнгө зарцуулж зөвлөмжийг биелүүлсэн нь онцлох ажил байлаа.

Жишээ нь ЗХЖШ 111 сая төгрөгөөр хяналт шинжилгээнд хамрагдсан оюутны дотуур байрны асуудлыг их дээд сургуулиуд 4 тэрбум 552 сая төгрөгөөр, оюутнуудад шаардлагатай тоног төхөөрөмж амьдралын орчныг сайжруулах чиглэлээр бол 479 сая төгрөгөөр бараа бүтээгдэхүүн авч ингэж ажилласан ийм дүн мэдээтэй байна. Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хамрах хүрээ бол 2025 онд өмнөх жилүүдээс хамгийн өргөн түвшинд хүрсэн. Илэрсэн эрсдэлийн шалтгаан нөхцөлийг нарийвчлан тодорхойлох боломж бүрдсэнтэйгээр холбоотойгоор зөвлөмж болон заалтын тоо өссөн үзүүлэлттэй.

Үндэсний механизмыг бэхжүүлж урьдчилан сэргийлэх ажиллагааны үр нөлөө дээшилж байгаа гэсэн ийм эерэг өөрчлөлтүүд гарч байгаа. Зөвлөмжийг хэрэгжүүлээгүй хариуцлага алдсан албан тушаалтанд хуульд заасан үндэслэлээр хариуцлага тооцуулах саналыг эрх бүхий байгууллага албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлсэн. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх явдлын хүрээнд бол нийт хүний эрх зөрчигдсөн талаарх 61 гомдол мэдээлэл ирүүлсэн. Энийг хуульд заасан үндэс журмын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд хуулийн хугацаанд мэдээлэл авч дүн шинжилгээ хийж тайланд тусгасан байгаа. Тайлангийн хугацаанд бол нийт 407 удаа сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгууллаа. Үүнээс ШШГБ-д 171 цагийг хамгийн их зарцуулсан. Нийт 55 мянган төрийн албан хаагч, иргэд, хүүхэд, оюутан залуучууд хамрагдсан ийм тоон мэдээлэлтэй байгаа. Мөн үйл ажиллагааныхаа далайцыг нэмэгдүүлэх зорилгоор 224 сургагч багшийг бид нар өмнө нь бэлдсэн. 2025 онд олон улсын Эрүүдэн шүүхийн нийгэмлэг болон бусад хууль сахиулах байгууллага, прокурор, прокурорын байгууллага бусад байгууллагатай хамтран 1100 албан хаагчийг мөрдөн шалгах ажиллагаанд мэдээлэл цуглуулах үр дүнтэй арга буюу мендизийн зарчмыг нутагшуулах энэ зорилгын хүрээнд сургагч багшаар бэлдсэн. Сургагч багш нар өөрсдийн байгууллагад танхимаар болон цахимаар сургалтыг төрийн албан хаагч нартаа үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Үндэсний ажиллагаа албан ёсоор хэрэгжиж эхэлснээс нийт 96 мянга гаруй хүнийг 605 удаагийн сургалтад хамруулсан дүн мэдээтэй байгаа. Олон нийтийн мэдээлэл сурталчилгааны ажлыг цахим орчинд нэлээн удаан хийлээ. Нийт 2.5 сая хүнд мэдээлэл хүрч ажилласан нь өмнөх оноос 3 дахин өссөн ийм үзүүлэлттэй байлаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх зорилгоор анх байгуулагдсан цагаас эхэлж төрийн байгууллагууд Хууль зүй байнгын хороо, Хүний эрхийн дэд хороотой хамтран ажиллаж байна. Үүнээс гадна олон улсын эрүүдэн шүүхийн нийгэмлэг, Эрүүдэн шүүхийн эсрэг дэд хорооны гишүүд бусад ажлын багтай хамтран бэхжүүлэх ажлыг 4 дэх жилдээ үргэлжлүүлж байна. Энэ жил өнгөрсөн жилийн тайланд хамгийн онцлог асуудал иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран 2025 онд хийж хэрэгжүүлэх ажлыг бол боловсруулан төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг тооцож ажиллалаа. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх энэ үйл ажиллагааны энэ удаагийн тайланд бид тодорхой судалгаа хийж бас тайландаа оруулсан. Энэ судалгаа бол эрүүдэн шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, саатуулах, ялгаварлан гадуурхах гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийлээ. Мөн шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийсэн ийм дүн мэдээтэй байгаа. Өнгөрсөн оны эрүү шүүлт тулгах гэмт хэргийн том статистик буюу Монгол УЕПГ-аас авсан дүн мэдээгээр 2 дугаар сарын 3-ны өдөр ирүүлсэн албан бичгийн хавсралтад дурдсанаар бол 2024 онд 29 гэмт хэрэг, 2025 онд 31 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. 2024 онд 13 хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан 9 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан бол 2025 онд 24 хэрэг бүртгэлтийнхийг хааж, 5 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагчаар татсан.

2024, 2025 оны үлдэгдэл хэрэг тус бүр 12 байна. Мөрдөн байцаалтын шатад 2024 онд 9 хэрэг, 2025 онд 5 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. Нотлох баримтыг бүрдүүлж шүүхэд шилжүүлсэн хэрэг бол 2024 онд 7, 2025 онд мөн 7 гэсэн ийм дүн мэдээтэй байна аа.

Цаашид эрүү шүүлт тулгах гэмт хэрэг болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг шалгах бүтцийг шалгах, бүтцийг байгуулах талаар гарсан Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх нь зүйтэй байна гэсэн ийм нэгдсэн байр суурьтай байна.

Улсын Их Хурлаас эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайланг хэлэлцэж жил бүр Их Хуралд хэлэлцүүлэх зүйтэй гэсэн асуудлуудыг оруулж 5 удаагийн тогтоол баталсан.

2025 онд Ерөнхий сайдын 2 дугаартай албан даалгавар гарч эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байдаг аа. Их Хурлаас баталсан дээрх тогтоолуудын хэрэгжилтийг Засгийн газраас хуульд заасан хугацаанд тайлагнаж хэрэгжилтийг бүрэн хангах нь бол эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ гэж үзэж байна. НҮБ-аас яг Монгол Улсад үндсэндээ 2016-2025 оны хооронд Засгийн газарт 8 удаагийн зөвлөмж ирүүлсэн. Энэ зөвлөмж бол үндсэндээ бол эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмыг бэхжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх ийм тодорхой зохицуулалтууд байсан. Цаашид бол эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг илүү үр дүнтэй бодитой хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын бүх түвшинд тодорхой хэмжигдэхүйц энэ тогтвортой үр дүн бүхий арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж ингэж дүгнэсэн. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас дээрх тайланг боловсруулахдаа цаашид эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор 14 саналыг бол гаргаж байгаа. Та бүхэн Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулах талаар хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү гэж хүсэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Цэлмэн даргад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Сайнзориг гишүүн бас асуулт асууна гэж байсан хаана байна. Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Үг тусдаа байгаа. Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Баярбаатар: Байнгын хорооны гишүүддээ өглөөний мэнд хүргэе ээ.

Нэгдүгээрт энэ материал 3 сарын 30 гээд он сартай тараагдсан юм байна. Энэ чинь хэдэн хуудас юм. 22 хуудас материал. Сая л хуралд орж ирэхэд тарааж байна. Дээр нь танай байгууллага ер нь ямар чиг үүрэгтэй байгууллага юм бол? Судалгаа хийдэг байгууллага юм уу эс үгүй бол урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг байгууллага юм уу? Яг ажлын чинь үр дүн бүтээмж та нарт сая энэ танилцуулгад чинь ерөөсөө харагдахгүй байна. Ямар мэргэжлийн улсууд юу хийдгийг чинь би ерөөсөө ойлгосонгүй. Сая та танилцуулгадаа Улсын Их Хурлын баталсан тогтоолыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм байна гээд нэг үг хэлчих шиг боллоо. Үгүй ээ хэрэгжүүлэх үүрэгтэй шүү дээ юу яриад байгаа юм бэ? Хэрэгжүүлэх нь зүйтэй биш бол яах юм? Тэгээд энэ юмандаа жоохон нухацтай хандахгүй бол Байнгын хороо гээд нэг ийм Улсын Их Хурлын бүтцийн байгууллага шүү дээ. Тэгээд орж ирээд нэг мэдээлэл хийсэн болдог, нэг танилцуулга тайлангаа танилцуулсан болдог. Тэгээд ажлын үр бүтээмж нь ерөөсөө юу ч байдаггүй. Тэгээд хэдэн орон тоотой ажилладаг юм танайх. ХЭҮК-ын доор байдаг юм байгаа биз дээ? Эс үгүй бол тусдаа байгууллага юм уу?

Хаана ямар ажил албан тушаал эрхэлж байсан улсууд танай байгууллагад юу хийж ажилладаг юм. Жишээлбэл сэтгэл зүйн хүн байгаа юм уу, танай байгууллагад? Тэгээд энэ тайланг чинь би сая зүгээр цухас гүйлгээд л харахад энэ чинь нэг тийм үр дүн харагдаж байгаа юм ерөөсөө алга. Нэг бол тэгсэн, тэгээгүй байна. Ингэх шаардлагатай байна. Энэ дээр чинь ерөөсөө үр дүн өнгөрсөн хугацааны энэ ажлын чинь үр дүн байхгүй байна шүү дээ. Тийм байгууллагад ийм ийм, ийм гомдлууд ирсэн шийдвэрлэгдээгүй, тэгээд доор нь ингээд ингээд, ингээд цаашид ийм ийм ажлыг хийх шаардлагатай байна.

Бид нар ийм ажлыг хийсэн, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулсан ийм үр дүнгүүд гарсан. Тэр эрүүдэн шүүлт нь ингэж ингэж буурсан. Хүний эрхийн талаасаа ийм ийм чиглэлээр арга хэмжээ авч ажиллаад өнгөрсөн хугацаанд ийм ийм арга хэмжээнүүд хийснээр ийм үр дүн гарсан гэдэг ийм өгүүлбэр бол уул нь энэ дотроос би хармаар байдаг. Тэгээд нэг ч тийм өгүүлбэр энд л байсангүй л дээ. Тэгээд би энийг л гайхаад байна. Тэгэхээр та нэг байгууллагынхаа талаар нэг чиг үүргээ нэг тодорхой нэг тайлбарлаад ийм хүмүүс ажилладаг юм. Өмнө нь ийм албан тушаал эрхэлж байсан хүмүүс өнөөдөр манай байгууллагад ийм чиг үүргээр ажилладаг юм. Зорилго нь ийм байгаа юм. Тэгээд тусдаа байгууллага юм уу эс үгүй бол ХЭҮК-той хамаардаг юм уу, тэр Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа юм бол одоо бас яаж хэрэгжүүлэх юм? Энэ талаар та нэг.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон тайлбар өгөх байх аа. Би зүгээр Баярбаатар гишүүнээ ингэсэн шүү. Энэ 7 хоногийн өмнө бүх гишүүдэд эдний энэ тайлангаа ирүүлээд энэ тайланг нь бүх гишүүдэд тараачихсан байгаа юм. Саяын танд тараадаг чинь бол нөгөө Улсын Их Хурлын Тамгын газар энэ тайланг хүлээж

аваад дүн шинжилгээгээ хийгээд Их Хурал өөрөө тарааж байгаа материал нь энэ байгаа шүү. Тэгээд юу асуултуудад та бас хариулаад явчих. 3 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Баярбаатар гишүүний асуултад хариулъя.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа бол Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд нийцэж орсны дагуу ХЭҮК-ын тухай хуульд 2020 онд өөрчлөлт орсноор бол эрх зүйн үндэс нь зохицуулагдсан. 2022 оны 6 сарын 2-ны өдрөөс үйл ажиллагаа эхэлсэн 4 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Үндсэн чиг үүрэг бол ХЭҮК-ын тухай хуульд заасан 4 чиг үүргийг хэргэжүүлдэг. Энд бол 1 дүгээрт хүн өөрөө гарч явах боломжгүй бүх газар буюу энэ хүнийг хуулийн дагуу богино, дунд, урт хугацаанд ямар нэгэн байдлаар эрх чөлөөг нь хязгаарлаж байгаа энэ газруудад хяналт шинжилгээ хийх хүний эрхийг зөрчиж байна уу, эрүүдэн шүүж байна уу хүнлэг бус харьцаа оруулж байна уу гэсэн энэ асуудлаар бол хараат бусаар хяналт шинжилгээ хийх ийм 1 дүгээр чиг үүрэгтэй.

Хоёрдугаарт бол бид нар энэ чиглэлээр сургалт нөлөөллийн ажлыг төрийн болон бүх төрийн албан хаагч нарт хийх ийм үүрэгтэй. Дээрээс нь иргэддээ мэдээлэл өгөх үүрэгтэй. Мөн энэ эрүү шүүлтийн хор аюулын талаар сургалт сурталчилгаа хийж олон нийтэд хор аюулын талаар тайлбарлаж таниулах ийм үүрэгтэй.

Дээрээс нь иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч болон дангаараа энэ сургалтын гарын авлага бусад зүйлийг боловсруулж ер нь соён гэгээрүүлэх ажлыг бас давхар хийх ийм үүрэгтэй байгаа. Нэмэлт протоколоор бол тодорхой үүргүүдийг заачихсан байдаг. Хүний эрхийн Комиссын тухай хуульд бол эрүүдэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа хүний эрхийн комисс 2-ыг яг тодорхой хуульчлаад заасан. Хүний эрхийн Комиссын тухай хууль дээр бол эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа гэж эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хараат бусаар бие даан хэрэгжүүлэх цогц үйл ажиллагааг хэлнэ гэж заасан байгаа. Хүний эрхийн Комиссын тухай хууль дээр Хүний эрхийн Комисс гэж бас хараат бус бие даасан байгууллагыг хэлнэ гэж ингэж заасан. Ингээд комисс 6 гишүүнтэй эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг хариуцна гэсэн ийм хуулийн зохицуулалттай. Манай орон тоо асуусан. Орон тоо бол өнөөдөр 7 албан хаагчтайгаар ажиллаж байгаа. Анх байгуулагдахад Монгол Улсын Засгийн газар НҮБ руу тайлан хүргүүлэхдээ 10 албан хаагчийн орон тоотойгоор байгуулагдаж хүргүүлсэн. Сая Засгийн газраас явуулсан орон тооны цомхотголоор 2 албан хаагч цомхотгогдсон. Ингээд 7 албан хаагчтай. Үндэсний хэмжээний үйл ажиллагаа явуулах ийм үүрэг чиглэлтэй ийм байгууллага байгаа.

Дараагийн асуудал бол Их Хурлаас бол эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тогтоолыг бол баталсан. 2023 онд 35 дугаар тогтоолын 4 дэх хэсэг эрүү шүүлттэй холбоотой асууя. Урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуудал. 2023 оны 12 дугаар сарын 22-ны 114 дүгээр тогтоол бол энэ эрүүдэн шүүхийн эсрэг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт судалгаа хийж танилцуулах ёстой асуудал байсан. Энэ бол биелэгдсэн.

2024 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 37 дугаар тогтоолын 8, 9 дэх асуудал дээр бол эрүүдэн шүүхтэй холбоотой.

Д.Цогтбаатар: Яах вэ гүйцээх үү? Хариулт би гүйцээлгэчих үү? Гүйцээе. 3 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Ингээд 2024 оны 37 дугаар тогтоол, 2025 оны 77 дугаар тогтоолын 6, 7 дахь хэсэг гээд эдгээр хэсгүүдэд заасан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний талаарх тогтоол бол үндсэндээ бол Засгийн газар, Их Хурлын тайлан болон бусад зүйлээр манай хийсэн судалгаагаар бас холбогдох заалтууд тодорхой хэмжээнд хугацаандаа биелээгүй байна гэж дүгнэсэн. Энийг бол биелүүлэх нь зүйтэй байна гэдэг зөвлөмжийг Ерөнхий сайдад 2026 онд хүргүүлсэн. Тэгээд зарим заалт биелж байгаа гэсэн ийм хариултыг ирсэн. Энийг тайландаа тусгасан байгаа. Тайлангийн онцлог бол тухайн жилд үндэсний ажиллагаанаас хийж хэрэгжүүлсэн ажил үр дүнгээ бүхэлд нь ингээд тайлагнадаг ийм онцлогтой учраас тайлангийн бүх хэсгүүд дээр тухайн бүлэг болгон дээр гарсан үр дүнгүүдийг ингээд тодорхой бичээд нотлох баримтын хамт ингээд танилцуулж байгаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Тайлантай танилцаж байна. Тэгэхдээ бүрэн гүйцэд танилцаж чадаагүй байна. Энэ 200, 300 хуудастай ном. Би 7 дугаар бүлэг эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, саатуулах, ялгаварлан гадуурхах гэмт хэргийн нөхцөл байдал гээд энэ бүлгээс зарим зүйлүүдийг тодруулъя. Хууль бусаар баривчлах саатуулах гэмт хэргийн нөхцөл байдал 2024 онд 8 хэрэг, 2025 онд нэг хэрэг бүртгэгдсэн, 87 хувиар буурсан. Ийм эерэг үзүүлэлт гарсан байна. Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн нөхцөл байдал 2024 онд 6, 2025 онд 3 энэ төрлийн гэмт хэрэг гарсан байна аа. Бас эерэг үзүүлэлттэй байна. 50 хувиар буурсан. Харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжийг тодорхойлсон. Гэсэн хэдий ч энэ гэмт хэргийн статистик үзүүлэлт буурах биш эсрэгээрээ өссөн байна. 2024 онд 29, 2025 онд 31 гээд ингээд.

Тэгэхээр одоо та бүхний ажлын үндсэн чиг үүрэг бол яг л энэ чиглэлийн гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох. Энэ зорилготой. Тэгэхээр яагаад энэ гэмт хэрэг эрүү шүүлт тулгах гэмт хэрэг өнөөдрийг хүртэл байсаар байна вэ? Яагаад өсөөд байна вэ? Энийг та бүхэн юу гэж дүгнэж үзэж байна вэ? Өнгөрсөн хугацаанд хяналт шалгалт хийгдээд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтүүд яагаад хэрэгжихгүй байна вэ? Хууль сахиулах байгууллагууд энэ дээр яагаад эрүү шүүлт тулгах энэ гэмт хэргийг үйлдээд байна вэ? Гаргаад байна вэ? Энэний цаана чинь дандаа хүний эрх зөрчигдөж байгаа, хүний эрх зөрчигдөж байгаа. Тэгээд энийг та бүхэн юу гэж үзэж дүгнэж байна? Цаашдаа ингээд өсөөд байх юм уу энэ чиглэлийн гэмт хэрэг 21 дүгээр зуунд хүний эрх гээд бид нар энд яриад байдаг яриад байдаг. Гэтэл яг нидр дээрээ хүний эрхийн зөрчил гарсаар байна. Эрүү шүүлт тулгасан гэмт хэрэг гарсаар байна, нэмэгдсээр байна, өссөөр байна. Энийг цаашдаа ингээд энэ байдлаар нь аваад явах юм уу? Ямар арга хэмжээ авч байна вэ? Энэ гэмт хэргийг үйлдсэн холбогдох ажил албан тушаалтнуудад энийг та бүхэн нэг хэлээдхээч.

Энэ дээр тодорхой хариулаарай. Их тодорхой юм асууж байна шүү дээ. 3 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Бусад хэргүүдээс эрүү шүүлт тулгах гэмт хэрэг бол өссөн үзүүлэлттэй байгаа. Анх эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа эхэлж байхад 2022 он хүртэлх сүүлийн 5 жилээр авч үзсэн дүн мэдээгээр нийтдээ 500 гомдол мэдээлэл 90-ээд хуулийн

байгууллагад түүнээс 3 хэрэг шийдвэрлэгдэж байна шүүхээр гэсэн ийм дүн мэдээтэй байсан. Өнгөрсөн онуудад бол 2 жил дараалан шүүхээр шийдэгдсэн хэргүүдийн тоо өссөн. Энийг бол юу гэж үзэж байна вэ гэхээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр нөлөө гэж харж байгаа.

Яагаад гэхээр иргэд бол 1 дүгээрт эрүү шүүлт гэж юу юм бэ гэдгийг таньж мэдэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулсан.

Хоёрдугаарт яг энэ чиглэлийн хэргийг мөрдөх, хянах энэ мөрдөгч, прокурор, энэ шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтыг НҮБ-ын байгууллага болон ОУБ мөн дотооддоо хамтраад ингээд үе шаттай зохион байгуулж ирсэн сургагч багш нарыг бэлдсэн. Одоо мөрдөх ажиллагаан дээр нотолбол зохих байдлуудаа ойлгож нотолж чаддаг болсон гэж харж байгаа. Шүүх рүү шийдсэн хэргийн тоо өсөж байгаа юм. Өмнө нь бол ихэвчлэн хувийн таарамжгүй харьцааны улмаас биед нь гэмтэл учруул гэх байдлаар эрүүдэн шүүх тэр шинжийг нь орхигдуулж ирсэн. Ийм үзүүлэлт криминологийн судалгаагаар хийгдсэн. Криминологичдын холбооны хийсэн судалгаан дээр гарсан байгаа. Тэгээд бид нар бол яг энэ чиглэлээр хуулийг ялангуяа эрүү шүүлт тулгах гэмт хэргийг бол Эрүүгийн хуульд нэг бүлэг болгох асуудлыг бол шийдвэрлэх нь зөв байна гэдгийг 1 дүгээрт Их Хурлын 37 дугаар тогтоол дээр бас оруулж Их Хурлаас баталсан.

Одоогийн байдлаар Эрүүгийн хууль дээр өөрчлөлт ороогүй байгаа. Мөн энэ төрлийн гэмт хэргийг мөрдөх бие даасан энэ албыг байгуулах нь зөв байна гэдгийг Их Хурлын тогтоолоор бас шийдчихсэн. Маш олон бай орнууд манайд ийм мэргэшсэн байгууллага байх ёстой гэсэн ийм зөвлөмж өгч ирсэн. Ингээд эрүү шүүлт тулгах энэ процесс бол үндсэндээ таньж мэдээд нотлоод нэгэнт нийгэмд тогтчихсон энэ сүүлийн энэ 30 жилийн асуудал бол өргөс авсан юм шиг арилахгүй байна. Ялангуяа энэ хариуцлагын механизм сул байгаа үед бол бас энэ асуудал нэг мөр цэгцрэхгүй байгаа юм. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүлээн авсан байгууллага албан тушаалтан 30 хоногийн дотор заавал биелүүлж бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Биелүүлээгүй бол буцаагаад тэр хүний албан тушаалаас бууруулах, огцруулах, чөлөөлөх, хуулийн этгээдийг татан буулгах түдгэлзүүлэх саналыг хүргүүлдэг. Зүгээр саналыг хүргүүлдэг. Энийг бол томилсон байгууллага албан тушаалтан нь өөрөө ямар хариуцлага тооцохоо шийдвэрлэдэг.

Өнгөрсөн онд бол 23 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан. Харамсалтай нь яг гишүүний хүргүүлсэн саналын дагуу шийдвэрлэсэн. Энэ хариуцлага тооцож байгаа асуудал бол ховор байгаа. Дотоод журмаараа юм уу бусад хуулиараа ингээд албан тушаалаас өөрчлөхгүй чөлөөлөхгүй зөвхөн сануулах ийм шийтгэл оноож байгаа. Цагдаагийн байгууллагын албан хаагчдын зүг дээр бол яг энэ комментыг хэлэх нь зүйтэй. Яагаад гэвэл сүүлд шийдэгдсэн хэргүүд бол бүгд цагдаагийн байгууллагатай холбоотой. Бид өнгөрсөн хугацаанд бол цагдаагийн байгууллагад нийт 23 удаагийн зөвлөмжийг өгсөн. Цагдаагийн ерөнхий.

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулах уу? Тэгээд дараа нь Сандаг-Очир гишүүн нэмж асуух уу? Тэгье гүйцээгээд хариульъя 3 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Ингээд цагдаагийн байгууллагад өнгөрсөн хугацаанд 21 аймгаар хяналт шинжилгээ хийх үүрэгтэй бид нар тогтмол очиж шалгаж байх хяналт

шинжилгээ хийж байх ёстой үүрэгтэй. Өнгөрсөн жил бол 16 удаа цагдаагийн газар хэлтсийн эрүүлжүүлэх саатуулах ба бусад газарт мэдүүлэг авах өрөөнд хяналт шинжилгээ хийсэн. Сүүлийн энэ мэдүүлэг авах ажиллагаа ялангуяа энэ олон улсын зарчмыг энэ эрүүдэн шүүх урьдчилан сэргийлэх зарчмыг нутагшуулах зорилгоор бол энэ мэдүүлэг авах өрөөний стандартыг УЕП-оос баталж бол бид нар яг энэ дээр хяналт тавьж хяналт шинжилгээ хийж ажилласан. Өмнө нь гарсан хэргүүд бол бүгд л цагдаагийн байгууллагын байр мөрдөгчийн өрөө гэсэн ийм байгууллага дээр цагдаагийн албан хаагч холбогдож үйлдэгдсэн энэ хэргүүд шүүхээр шийдэгдээд байгаа. Тэгэхээр энэ гол асуудал цагдаагийн байгууллагын энэ үйл ажиллагаанд бас эргээд цогцоор харах шаардлага байна гэж харж байгаа.

Ялангуяа энэ тогтсон хэв шинжийг арилгахад маш их хүн хүч хүний нөөц.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Танайд яг энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон иргэдээс гомдол ирсэн үү? Надад эрүүдэн шүүлтийн гэмт хэрэг тохсон. Би ийм хохирогч боллоо гээд. Хэрвээ ийм хохирогчоос гомдол ирвэл танайх хэрхэн яаж авч хэлэлцдэг юм, ийм кэйс тохиолдол байна уу гэдгийг нэгд тодруулъя.

Хоёрт та бүхэн чинь бас л тэгээд л шүдгүй арслан юм байна шүү дээ. Саналаа өгдөг. Тэгээд эрүүдэн шүүлт хийчихсэн, холбогдох албан тушаалтнууд, томилсон албан тушаалтнууд нь ямар арга хэмжээ авах нь тэдний эрх үүрэг гээд ингээд бид нарт ямар ч эрх мэдэл байхгүй гээд ингээд сууж байдаг. Тийм учраас энэ төрлийн гэмт хэрэг чинь буурахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр та нар цаашдаа энэ Хууль зүйн байнгын хороотойгоо хамтарч, Хууль зүйн яамтайгаа хамтарч энэ дагасан хариуцлагын асуудлыг чангаруулах асуудлыг ярьж хэлж.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон өгье.

Я.Цэлмэн: Сандаг-Очир гишүүний асуултад нэмж хариулъя. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны гол зорилго бол урьдчилан сэргийлэх байгаа. Бид гомдол хүлээж аваад шалгах ийм механизм процесс байхгүй. Харин хуульд заасны дагуу холбогдох байгууллага шалгах эрх бүхий байгууллага руу хуулийн хугацаанд шилжүүлдэг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд 11 бүрэн эрх дээр нэг бүрэн эрх байдаг бол эрүү шүүлт тулгах гэмт хэргийг харьяалан шалгуулах газар нь шилжүүлж шалгуулах эрх байгаа. Тийм учраас бид нар энэ төрлийн гомдол гаргасан иргэдийн өргөдөл гомдлыг хүлээж авдаг. Бид нар дээр эрүү шүүлт тулгасан чиглэл гомдол болон бусад байдлаар хохирсон гомдол өнгөрсөн 4 жилийн хугацаанд 230 ирсэн. Энэ жил бол 61 гомдол ирснийг шилжүүлж шалгуулсан. Эргээд бид нар гол нь хэрхэн яаж шалгасныг заавал эргэж авч тэгээд тайландаа тусгаж байгаа.

Д.Цогтбаатар: Хангалттай юу? Нэг тодруулъя. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: ХЭҮК-оос байгаа тиймээ. Энд ажлын хэсэг дээр байхгүй билүү. ХЭҮК-ын эрүүдэн шүүлтийн. Гэхдээ бусад ХЭҮК-ынхоо гишүүдтэйгээ яаж хамтран ажилладаг юм та нар. Танайхан чинь бас ХЭҮК дотроо бас тусгайлан вант улс болчихоод байна аа. Хамтарч ажиллахгүй байна гэдэг ийм санал хүсэлтүүд байгаад байна. Энэ одоогийн зохицуулагдаж байгаа хууль эрх зүйн орчноороо яг энэ бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн давхардал юмнууд чинь хэр нийцэж

байгаа юм? Энийг тусад нь гаргах ёстой юм уу, яах ёстой юм. Хоорондын бусад гишүүдтэйгээ хоорондын ажлын уялдаа холбоо чинь ямаршуухан байгаа юм бэ? Энийг нэг та нар харин бас нэг хэлээдхээч.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Бидний нэгдэн орсон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протокол дээр нэгдэж орсон улс бол тухайн улсдаа эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэг буюу хэд хэдэн байгууллагыг байгуулна гэсэн ийм заалттай конвенцод нэгдэж орсон. Энэний дагуу 2020 онд Хүний эрхийн Комиссын тухай хуульд Хүний эрхийн Комиссын тухай хуульд өөрчлөлт орсон. Энэ өөрчлөлт орсон зохицуулалтаар эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд Хүний эрхийн Комиссын гишүүн болон бусад албан тушаалд хөндлөнгөөс нөлөөлөх оролцохыг хориглоно оо гээд заачихсан учраас бид нар мөн хараат бус бие даасан цогц ажиллагаа гээд энэ хоёуланг нь заачихсан учраас яг энэ чиглэлээрээ ажилладаг.

Хүний эрхийн Комиссын дарга эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ гэсэн ийм зохицуулалттай. Энэ хүрээндээ бид нар хамтарч ажилладаг байгаа.

Д.Цогтбаатар: Тулга гишүүний микрофоныг өгье.

Б.Тулга: Та бүгдийн энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Тэгэхээр энэ тайлантай танилцсан тэгээд тайлангийн энэ 330 дугаар хуудсан дээр байгаа дүгнэлтүүд дээр бас холбож асуулт асууя гэж бодож байна. Хуулийн хэрэгжилтийг үр дагаварт хийсэн үнэлгээгээр Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн эрүү шүүлтийн урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйг зохицуулсан 22 заалтаар үнэлэхэд зорилгод хүрсэн байдал нь 50 хувь, практикт нийцэж байгаа байдал нь 22.7 хувь гэж дүгнэсэн байна аа.

Тэгэхээр энэ хэрэгжилт сул байгаагүй учир шалтгаан цаашид хэрхэн сайжруулах талаар бас ямар бодлого баримталж байгаа талаар мэдээлэл өгмөөр байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ Байнгын хороо Хууль зүйн байнгын хорооноос гарсан хэлэлцүүлж олон тогтоолууд гарсан байгаа. Тэгэхээр эдгээр тогтоолын хэрэгжилт хангалтгүй бөгөөд Засгийн газраас тогтоолын хэрэгжилтийг хангах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй байна гэсэн ийм тайлан гаргасан байна. Тэгэхлээр үүний учир шалтгаан нь юунд байгаа гэж бодож байна? Засгийн газарт хандсан зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг хангах тал дээр яг ямар ямар ажлууд та бүхэн хийв ээ. Ер нь цаашид ямар байдлаар ажиллавал үр дүнд хүрнэ гэсэн ийм бодолтой байна?

Гуравдугаарт, одоогийн эрх зүйн зохицуулалт хэм хэмжээ нь холбогдох конвенц болон нэмэлт протоколын шаардлагад бүрэн нийцээгүй гэдэг маягаар тайланд орсон байна. Мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа чиг үүргээ олон улсын эрх зүйн актад тусгасны дагуу бие даасан, хараат бусаар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл үл ойлголцол үүсэж байна гэсэн ийм одоо дүгнэлтүүд

хийсэн байх юм аа. Тэгэхээр энэ олон улсын стандарт бүрэн нийцээгүй гэж дүгнэж байгаа. Энэ талаар хэрхэн сайжруулах талаар яг ямар арга хэмжээнүүдийг та бүхэн төлөвлөж байна вэ? Цаашид ер нь ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ гэсэн ийм 3 асуултыг тавья.

Дөрөвт нь бас нэмээд энэ сургуулийн дотуур байр ахмадын сувилал энэ тэр гээд энд танай юунд ороод ирсэн байх юм? Тэгэхээр энэ армийн доторх энэ дэглэлт мэглэлтийн асуудал чинь бас танайх үйл ажиллагааны хүрээнд хамарч судалгаа шинжилгээ хийж ажиллах ийм талбар мөн үү биш үү? Хэрвээ мөн бол энэ дээр ямар ямар арга хэмжээ авч хэрэгжиж байна аа? Одоо энэ сүүлийн үед энэ дэглэлтүүд гараад байна шүү дээ. Хилийн цэрэг, дотоодын цэрэг ардын арми дээр гэхлээр. Энэ тал дээр энэ тайлан дээр бас тодорхой юмнууд тусаагүй байх шиг байх юм. Хэрвээ энэ хамаардаг бол энэ тал дээр ямар арга хэмжээнүүд авсан бэ гэдэг ийм асуултыг тавих гэсэн юм 4 асуулт.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон хариулъя.

Я.Цэлмэн: Тулга гишүүний асуултад хариулъя.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн судалгаа хийх Их Хурлын тогтоол бол 2023 онд гарсан 114 дүгээр тогтоол. Үүний дагуу Хууль зүйн байнгын хорооноос бол судалгаа хийлгэсэн үр дүнг ингээд танилцуулсан эрдэмтдийн судалгаа хийж. Үүн дээр хэрэгжилтийн олон улсын 1 дүгээр улсын конвенц, НҮБ-ын эрүүдэн шүүхийн хороо болон дэд хорооноос өгсөн зөвлөмжүүд мөн бусад орноос өгсөн зөвлөмжүүдийн дагуу хараат бусаар байгуулах нь зүйтэй үйл ажиллагааг нь цаашид бэхжүүлэх шаардлагатай гэсэн ийм зөвлөмжүүд удаа дараа ирсэн байдаг.

Яагаад энэ дээр ингээд удаа дараагийн Улсын Их Хурлын Тамгын газрын дүн шинжилгээ болон Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дүн шинжилгээн дээр ингэж дурдагдаад байна гэхээр өөрөө энэ хууль эрх зүйн зохицуулалт болон хараат бус байдлын талаарх авагддаг энэ хэдэн шинжүүдтэй холбоотой байгаад байгаа. Төсөв санхүү болон хүний нөөцийн удирдлага гэсэн энэ байгууллагын хэв шинжийг агуулдаг эдгээр зүйлс хоорондоо бол хуулийн хуулийн зохицуулалтын хувьд бол хоорондоо энэ бас зохицуулах цаашид боловсронгуй болгох шаардлагатай гэж ингэж гарсан. Энэнтэй холбогдуулаад Их Хурлын 37 дугаар тогтоол, 2024 оны 37 дугаар тогтоол гарч яг олон улсын энэ зөвлөмжүүдэд нийцүүлж ХЭҮК-ын тухай хуульд өөрчлөлт оруулж эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж бэхжүүлэх шаардлагатай гэсэн ийм тогтоол батлагдсан.

Хоёрдугаар асуулт бол Засгийн газарт бид сая зөвлөмж 2026 онд хүргүүлсэн. Энд Их Хурлын тогтоолуудыг дандаа Засгийн газарт биелүүлэхээр үүрэг болгож өгсөн байдаг. Энэ тогтоолуудаа хэрэгжүүлж өгөөч гэж хүссэн. Энэ тогтоолууд дандаа эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүгийн хуулийн өөрчлөлт бүлэглэх асуудал олон улсын эрүүдэн шүүхийн хороонд Монгол Улсаас гомдол гаргах эрх, тэгээд хараат бусаар мөрдөн шалгах ажиллагааны асуудал гээд цогцоор нь ингээд жил дараалан шийдүүлсэн ийм тогтоолын асуудлууд байгаа юм аа.

Дараагийн асуудал бол сургуулийн энэ дотуур байраас гадна энэ цэргийн сахилгын байрны асуудал дээр л бид нар цэрэг дээр яг хяналт шинжилгээ хийх талаар ингээд хуульчилчихсан байдаг. Манай хууль дээр бол яах вэ олон улсын

конвенцоо дагах ёстой гэдэг хүний эрхийн комиссын тухай хуулийн заалтыг барих юм бол бид нар бүх хүн өөрөө гарч явах боломжгүй газруудаар хяналт шинжилгээ хийх боломжтой. Сүүлийн үед Зэвсэгт хүчин ялангуяа энэ Жанжин штаб бид нартай ямар чиглэлээр хамтарч ажиллаж байгаа вэ гэхээр сургалт нөлөөллийн чиглэлээр сургагч багш бэлтгэх, хамтран сургалт хийх ийм нөлөөллийн ажил хийх чиглэлээр маш эрчимтэй ажиллаж байгаа.

Дээрээс нь сүүлийн гучаад жил засварлаагүй байсан цэргийн сахилгын байраа өнгөрсөн жил 111 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж засаж мөн баримтлах журмыг нь прокуророос шинэчлэн боловсруулж баталсан. Бүс нутагтаа тэргүүлэх ийм сахилгын байр болсон. Тэгээд дотроо яг сахилгын байрны чиглэлээр болон цэргүүдийг хотод ирэх үед байрлуулах ийм зохион байгуулалтаар ажиллагаанд оруулж ингэж тайлан мэдээнд.

Д.Цогтбаатар: Тодруулах уу? Тулга гишүүн Тулга гишүүн тодруулъя.

Б.Тулга: Тэгэхээр эхний асуултад та бас жоохон дутуу л хариулаад байна. Тайлан дээр чинь өөрөө танай хууль дээр байгаа 22 эрх зүйн зохицуулалт чинь 22 заалтаар үнэлэхэд гэж байгаа шүү дээ. Тэгэхээр зорилгод нийцсэн байдал 50 хувь, практикт нийцсэн байдал 22.7 гээд байгаа байхгүй юу. Тэгэхлээр энэ чинь бараг ер нь бол хэрэгжихгүй байна гэсэн ийм дүгнэлт хийчхээд байна шүү дээ. Тэр практикт нийцэхгүй байдал 22 гэдэг дээр яг ямар шалтгаан байгаад байгаа юм бэ гэдэг дээр та нэг тодорхой хариулаадахмаар байх юм.

Дээр нь тэр 3 дахь асуултыг би яг 4 асуулт томъёолоод уг нь хариуллаа. Тэгээд хольчихлоо. Та 3 дахь асуулт нь тэр олон улсын юунд олон улсынхаа гэрээ конвенц дээр олон улсын стандарттай бүрэн нийцээгүй гэсэн дүгнэлт дээр ямар яг юун дээрээ нийцэхгүй байгаа юм бэ гэдэг ийм асуулт байгаад байгаа шүү дээ. 3 дугаар асуулт. Тэгэхээр энд дээр нэг.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон хариулъя.

Я.Цэлмэн: Тулга гишүүний асуултад хариулъя. Их Хурлын 114 дүгээр тогтоол дээр түрүүн хэлсэн. Энэ хуулийн хэрэгжилтийн үр дагаварт судалгаа хийж танилцуулах шаардлагатай гээд үүн дээр эрдэмтэн судлаачдын баг гарч Конвенцын нэгдэн орсон конвенц болон Хүний эрхийн Комиссын тухай хуулийн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтын хоорондын нийцэл түүний үр дагаварт судалгаа хийж танилцуулсан байгаа. Энэ судалгаан дээр бол яг энэ нэгдэн орсон конвенцынхоо дагуу бүрэн эрхийг баталгаажуулах чиглэлээр түрүүний хэлсэнчлэн хүний нөөц, төсөв санхүү түүн дотор ажиллах алба хаагчдын шаардлага, эдгээр зүйлстэй холбоотой энэ асуудлыг бүрэн шийдээгүй байна. Хэт комиссоосоо хараат байна гэдэг ийм дүгнэлтийг гаргасан. Тийм учраас хэрэгжилт 22 хувьтай байна гэж гарсан.

Тодорхой жишээ хэлэх юм бол эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн бол нэгжийнхээ даргыг томилно. Манай нэгжийн дарга өнөөдрийг хүртэл хэнийг ч томилохгүй. Ийм байдалтай байгаа.

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Тэгэхээр энэ 2025 оны үйл ажиллагааны тайлан гээд энэ Улсын Их Хуралд энэ тайланг ирүүлдэг. Энэ бол ХЭҮК-оос тусдаа ирүүлдэг тайлан байгаа. Өөрөө яагаад тусдаа ирүүлдэг юм бэ гэхээр энэ өөрөө тусгай статустай ийм байгууллага. Хэрвээ зүгээр ХЭҮК-ын нэг доор нэг байгууллага ч юм уу нэгж бол энэ тайлан нь хамт л ирнэ. Яагаад ингээд тусдаа ирдэг юм бэ гэхээр өөрөө цаанаа олон улсын гэрээ конвенцод нэгдэн орсон тэр бүх шаардлага бүх зүйлийг уялдуулж ингэж гаргадаг. Манай дээр би бол манай Хууль зүйн байнгын хорооны гишүүд сууж байгаад энэ байгууллагын статусыг нэг сайн яриасай гэж боддог. Яагаад гэхээр бид нар бүх юмыг ингээд монголчлох гээд байдаг байхгүй юу. Олон улсын гэрээ конвенцоороо ийм байна яагаад энэ хараат бус байх ёстой юм бэ гээд заачихсан байхад үгүй эднийх дотроо вант улс байгуулах гэж байна. Энэ гэж нэг тусдаа нэг дураараа нэг аашлах гэсэн дарга болох гэсэн хүмүүс гээд ингээд буруу ойлгоод байдаг байхгүй юу.

Би бол энэ дээр хуульч хүртэл санаачилж байсан тэгээд л ерөөсөө ингээд л энэ байгууллагын тухай ярихгүй хүнийг нь яриад байдаг байхгүй юу. Үгүй энэ Цэлмэн дарга чинь ингээд байсан юм тэгээд байсан юм гээд. Тэгэхээр бид нар энэ байгууллагыг яг тэр монголчлохгүйгээр олон улсын стандартынх нь дагуу хараат бус байлгах ёстой. Яагаад эрүүдэн шүүлтийн үйл ажиллагаа чинь дандаа дээрээс том даргын захиалгаар том артай байж байж хийгддэг гэдэг нь улс орон болгонд тодорхой байгаа учраас энийг хараат бус байх ёстой. Энэ ОУБ-ынхан чинь нэг удаа ирээд хориход шөнө очоод гэнэтийн шалгалт хийх гэтэл л бүх дарга нар нь мэдчихсэн байсан гэж байгаа байхгүй юу. Яагаад гэхлээр энэ чинь нууц байх ёстой. Дарга мэдэхгүй байх ёстой. Тэр хөрөнгө мөнгөө зарцуулдаг нь бүгд ингээд хараат бус байтал дандаа даргаас. Тэгээд л мэдээлэл задардаг. Очиход бүх хүн юм нь ингээд юу ч болоогүй юм шиг ингээд байж байдаг. Болохгүй би энэ комиссаруудтай чинь олон уулзаж байсан юм.

Тэгээд эднийх харин 8 хүнтэй гэхэд маш сайн ажиллаж байгаа гэж би зүгээр хувь гишүүнийхээ хувьд үздэг. Одоо энэ Үндэсний үйл ажиллагаа гээд олон газар хийсэн. Энэ үндэсний үйл ажиллагааг бол сая Тулга гишүүн асуулаа. Бид нар цэргийн ангиуд дээр хийхээр би дараагийн долоо хоногт хууль өргөн барих гэж байна. Энэ дээр манай гишүүд бас бид нар хамтраад энэ хэлэлцүүлгийг нь хийгээд энэ үндэсний үйл ажиллагааг энэ цэргийн ангиуд дээр явуулах юм бол энэ цэргийн ангиуд дээрх эрүүдэн шүүх ажиллагаа зогсоно, багасна, хүмүүс нь ойлголттой болно. Эрүүдэн шүүх гэдэг чинь зөвхөн зодоод занчаад байдаг юм биш энэ чинь удаан цагаар хоолгүй байлгах, хүйтэнд зогсоох, нэр төрийг нь доромжлох. Энэ чинь бүгд эрүүдэн шүүх гэдгийг хэлэх гэсэн юм аа. Би нэг минутаа нэмж аваад нэг юм асуух гэсэн юм аа.

Энэ үе тэнгийн дээрэлхэлт гээд нэг айхтар асуудал гарчихсан. Энэ чинь энд байгаа хүүхдүүд чинь хүмүүжихгүйгээр том болоод яг нэг хүмүүсийг эрүүдэн шүүдэг хүмүүс болж хувирна. Одоо түрүүн бас Цогтбаатар дарга ярьж байсан. Терроризм юун дээр чинь энэ бүүр багаас нь.

Д.Цогтбаатар: Нэг минут нэмээд өгье Одонтуяа гишүүнд.

С.Одонтуяа: Багаас нь ингээд одоо ийм асуудал үүсдэг гэж. Тэгэхээр энэ олон улсын практикт ямар нэгэн аргачлал байдаг юм уу энэ хүүхэд залуучуудын дунд энэ дээрэлхэлтийг багасгах тийм үү нөлөөллийн ажил явуулах гээд. Та нарын

энэ нөлөөллийн ажлыг би харлаа л даа. Тэгэхээр энэ иргэдэд зориулсан энгийн контентыг нэмэгдүүлэх, сайжруулах гээд ингээд өөрсдөө бичсэн байна. Тэгэхээр энэ тал дээр ямар нэгэн тийм олон улсын судалгаанууд байдаг юм уу? Энэ талаар нэг хариулж өгөөч гэж хүсэх гэсэн юм. Энэ бол бид нарын хувьд маш их тийм сэтгэл эмзэглүүлсэн асуудал байгаа. Энэ чинь зүгээр хүүхдийг зодоод байгаа юм шиг мөртөө энэ чинь бүүр яг эрүүдэн шүүж байгаа байхгүй юу. Бүүр үнэхээр бүүр тэр бичлэгийг нь үзэхээс ч нүд халтирмаар. Тэгээд энэ дээр та нар мэргэжлийн хүмүүс байна энэ дээр нэг сайхан хариулж өгөөч гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Гуравдугаар микрофон.

Я.Цэлмэн: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны яг зохицуулалтаар бид нар оюутны дотуур байр, хүүхдийн дотуур байр, суралцагчдын дотуур байр, тэгээд асрамж халамжийн төвүүдэд байгаа хүүхдүүдийн эрхийн асуудал дээр голчлон анхаарч урьдчилан сэргийлж ажилладаг. Монгол Улсад үндсэндээ нэг 20 байгууллагын, 29 хүүхдийн асрамж халамжийн төв үйл ажиллагаа явуулж байгаа. Үүнд бол 900 орчим хүүхэд ингээд хамрагдсан байдалтай байдаг. Бид өнгөрсөн хугацаанд тодорхой үе шаттайгаар холбогдох стандартуудыг шинэчлэх хүний эрхийн зарчимд нийцүүлэх чиглэлээр хамтарч ажиллаж байгаа. Өнгөрсөн онд оюутны дотуур байрны стандартыг Монгол Улс дахин шинэчилж батлуулж Хятад сургуулийн оюутны дотуур байрыг батлуулж чадсан. Энэ үе тэнгийн дээрэлхэлтэй холбоотой асуудлын талаар бол зүгээр суурь шалтгаануудыг л хамгийн түрүүнд төрөөс анхаарч зохицуулж өгөх нь үе тэнгийн дээрэлхэлтийн асуудлыг шийдвэрлэхэд нэлээн том түлхэц болно гэж ийм олон улсын судалгаа байдаг.

Бид нар ч гэсэн энэ судалгаатай танилцаж яг энэ чиглэлээр тодорхой саналыг энэ 2025 оны тайланд оруулсан. Тэр нь юу байна гэхээр энэ 29 хүүхдийн асрамж халамжийн байгууллагын 3 л төрийн төсвөөр санхүүждэг, бусад нь сайн санаат иргэдийн болон гадаадын иргэдийн ТББ-ын төсвөөр санхүүжиж байгаа. Энэ дээр харилцан адилгүй ийм нөхцөлд хүүхдүүд амьдарч суралцаж байгаа. Жишээ нь би нэг зүйлийн жишээг хэлэхэд 1-ээс 5 дугаар ангийн хүүхдэд энэ цахим платформ дээр хичээл орж байгаа. Энэ асуудал дээр асрамж халамжийн байгууллагын хүүхдүүд байгаа. Энэ төсөв дээр энэ цахим платформын хичээлийн төсөв байхгүйгээс хүүхдүүд хичээлдээ яг тэр цахимаар үздэг утас таблет ашигладаг ийм хичээлүүд дээрээ энэ асрамж халамжийн төвийн хүүхдүүд оролцож чаддаггүй. Сургууль бас яг тэр цагууд дээр бас ялгаварлан гадуурхагдахгүйн тулд багш нар нь гаргадаг гээд иймэрхүү хүндрэл бэрхшээлүүд байдгийг тайландаа оруулсан. Тэгэхээр энэ сургалттай холбоотой төсвийг бол энэ 900 хүүхдийн асуудлыг нэг мөр шийдэх нь зөв байна гэж харж байгаа. Ялангуяа бие даалттай холбоотой ч гэсэн маш их зардал энэ сургалт ерөнхий боловсролын сургуулиудаас бас гардаг юм байна. Энэ дээр ихэвчлэн багш нар нь өөрсдөө цалингаасаа зохицуулаад явж байдаг л ийм асуудлууд байгаад байгаа.

Тэгэхээр иймэрхүү ялгаатай байдлаас болоод хүүхдүүдийг үе тэнгийн дээрэлхэлтийн бас нэг ийм шалтгаан болж байгаа гэж ингэж судалгаан дээр авч үзсэн байгаа юм аа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Саяын тэр энэ хүүхдийн юутай холбогдуулаад нэг ийм юм та нар бодож ажиллаарай. Мэдээж хэрэг эрүү шүүлт гэдэг энэ Монголд хэрэглээд сурчихсан нэр томъёо байгаад байна аа. Гэхдээ энэ порчер гэсэн үг шүү дээ. Тэгээд

манайх нөгөө Монгол хэлэндээ арай зөөллөж гоё болгож. Энэ зөөллөх тухай асуудал байх биш байхгүй юу. Энэ чинь эрх зүйн тухай ойлголт болохлоор байгаагаар нь л ер нь нэрлэж байх ёстой юм байгаа юм. Яг бүүр бодит утгаараа энэ үг тарчлаах, онц хэрцгийгээр харьцах тухай энэ асуудал шүү дээ. Энэ дээр гэхдээ яах вэ энэний нэг гол юм нь бол харин заавал 2 элемент байх ёстой. Төр иргэнтэй харьцаж байх тухай асуудал. Тэгэхээр саяын сургуулийн асуудал бол ингээд харахад бол нөгөө хүүхэд хүүхэдтэйгээ харьцаж байгаа учраас яг энэ конвенцын рестикц буюу мандатад хамаарахгүй асуудал мэт боловч та хэд нэг өнцгөөс нь харах ёстой. Ийм юм болоод байхад тэр чинь нөгөө насанд хүрээгүй хүүхдүүд байгаа болохлоор бие даасан хуулийн этгээд өөрсдөө болоогүй хариуцлага хүлээх болоогүй байгаа тохиолдолд энэ дээр бусад нийгмийн оролцогчид хариуцлага хүлээх болчхож байна шүү дээ. Тэрэн дотроо төр. Яагаад гэвэл тэр чинь нөгөө сургуулиуд дээр чинь үйлчилж байгаа хууль энийг дүрэм журам энийг чинь боловсруулж байгаа нь энийг урьдчилан сэргийлэх ажлыг төр хийгээд ийм юм болоод байхад нүдээ аниад хаахгүй, нүдээ аниад харахгүй өнгөрч байгаа бол арга хэмжээ хүчин чармайлт авахгүй байгаа төр энийг өөгшүүлээд байж байна гэсэн үг байхгүй юу.

Тэгэхлээр энэ утгаараа шууд утгаар биш гэхэд тойруу утгаар эс үйлдлээр энд төр хариуцлага хүлээх нөхцөл байдал үүсэж байгаа шүү. Тэгэхээр энийгээ та нар бас тал талдаа бид нар бодолцох ёстой. Ялангуяа би Байнгын хорооныхондоо энэ нэгэнт Одонтуяа гишүүн чухал асуудал хөндөөд ярьж байгаа болохлоор сая ч би тэр Европын аюулгүй байдлын хамтын ажиллагааны Парламентын Ассамблейн терроризмын эсрэг хорооны хуралд оролцож байхдаа яг энэ асуудлыг ярьж явлаа. Энэ сургуулиуд дээр явагдаж байгаа энэ барууны соёлтой орнуудад явагдаад байгаа зүйл шүү дээ. Хүүхдүүдийн дунд явагдаж байгаа энэ радикализац гэдэг чинь энэ скүүл буллинг буюу эндээс эхэлж байгаа шүү.

Тийм учраас бүүр тэр дараагийн шатад орохоос нь өмнө энэ дээр нь анхаарч ажиллаж байх ёстой. Энэ талаараа бол манай улсад ч гэс гэсэн энэ чиглэлийн дэмжлэг туслалцаа хэрэгтэй байгаа гэдгийг ярьж ирсэн байгаа. Манай Байнгын хорооноос энэн дээр бид нар онцгой анхаарч манай гишүүд бас идэвхтэй оролцоорой. Энэ дээр сургуулийнхантай, хүүхдүүдтэй цагдаатай манай Байнгын хороо бол анхаарч ажиллаж энэ дээр бүүр тогтоол гаргаж ажиллах ёстой. Түүнээс 2 өдөр сошиал үзчихээд баахан цочирдож ярьчихаад өнөөдөр мартчихсан энийг ярихгүй явах юм бол цаад булан тойроод энэ чинь үргэлжилсээр л байгаа зогсоогүй байж байгаа. Энэн дээр тэгэхлээр Цэлмэн дарга бас судалгаа хийгээд энэн дээр бид нарт санал өгөөд ажлын хэсэгт ороод орох ёстой шүү. Тогтоол гаргана гэдэг бол Байнгын хорооноос ажлын хэсэг гарах хэрэгтэй болно оо гэсэн үг.

Тэгээд энэ дашрамд хэлэхэд бид нар Сандаг-Очир даргын Байнгын хороон дээр хэлэлцэгдэж байгаа хуульд ХЗБХ-гоо Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо гэж нэрлэе гэдэг томъёолол санал болгоод өгчихсөн байгаа гишүүдтэйгээ бид нар урьдчилж яриад. Та хэдийнхээ дэмжлэгийг аваад. Тэгэхээр энэ агуулгаараа ч гэсэн жишээлбэл хүүхдийн ийм асуудал бид нар дээр онцгой анхаарч ажиллах ёстой. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Надад нэг 2, 3 асуулт байна. Манай Их хурлын хяналт шинжилгээ, үнэлгээнийхэн бас миний эхний асуултад хариулаад өгөөрэй. Та бүхний энэ хийсэн дүгнэлт тайлантай танилцлаа. Тэгээд ерөөсөө энэ дээр яг үр дүнд суурилсан байдлаар энэ дүгнэлт тайлан гараагүй байна аа. Энэ дотроо тэгэхдээ бас

үр дүнд суурилсан байдлаар энэ тайлан энэ нэгж өөрөө тэгж анхнаасаа тайлангаа ирүүлэх ёстой гэдэг зүйлийг дурджээ. Цаашид яг энэ байгууллагын хувьд ялангуяа энэ эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх яг энэ нэгжийн хувьд яаж энэ үр дүнд суурилсан байдлаар энэ тайланг нь гаргуулах вэ. Одоо энэ тогтоол дээр юу тусгах вэ гэдгийг л би тодруулах гээд байгаа юм. Та хэдийн тогтоол дээр оруулах санал дотор чинь тэр бас ороогүй байна. Илүү дандаа энэ байгууллагын дотоод асуудал руу орсон байдлаар ийм санал чинь гарсан байна. Энэ байгууллагын төсвийн тухай, хүний нөөцийн тухай санал гарсан байна. Би бол тэрнээс илүү яг энэ байгууллагын үйл ажиллагаа нь өөрөө хэр үр дүнд суурилсан байдлаар явж байгаа юм, хэр үр дүн гарч байгаа юм бэ гэдгийг нь олж хармаар байгаа байхгүй юу.

Гэтэл тэр нь ерөөсөө харагдахгүй байна гэсэн үг. Тэгэхээр яг энэ үр дүнд суурилсан байдлаар энэ тайланг гаргах тал дээр нь Их Хурлын зүгээс бас энийг анхаарах ёстой байх аа. Энэ дээр нэг тайлбар сонсмоор байна аа.

Хоёрдугаарт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа гэж байгаа юм. Урьдчилсан сэргийлэх чиг үүрэгтэй байгууллага. Танай дээр гомдол ирж байгаа юу? Гомдлын мөрөөр та нар ажиллаж байгаа юу? Хэдэн гомдол ирсэн? Гомдлын мөрөөр хэрхэн ажилласан бэ гэдгийг надад нэг хариултаа өгөөдхөөч. Энэ танай дээр ирсэн тайлан дээр бол хэдэн хэд хэдэн гомдол ирсэн гээд ингээд дурдчихсан юмнууд байгаад байна. Би тэгээд урьдчилсан сэргийлэх нь үү гомдлын мөрөөр ажиллах уу гэдэг дээр чинь и эргэлзээд байгаа учраас энэ асуултыг асууж байгаа юм.

Гуравдугаарт түрүүн Одонтуяа гишүүн дурдсан энэ байгууллагын бие даасан статусын талаар ярих хэрэгтэй гээд энэ чинь хяналт шалгалт гээд. Тэгэхээр чинь яг нөгөө хяналт шалгалт урьдчилан сэргийлэх энэ тэр гэдгийг бид нар сайн ялгаж салгаж ярилцахгүй бол болохгүй байна аа. Ялангуяа одоо миний мэдэж байгаагаар яг энд сууж байгаа энэ бие бүрэлдэхүүний, энэ байгууллагын бие бүрэлдэхүүний тал нь Цагдаагийн академийн багш байсан хүмүүс сууж байна. Гэтэл энэ нэгжийн харьяалан шалгах ёстой урьдчилан сэргийлэх нэгж нь дандаа цагдаагийн байгууллага нөгөө Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба. Яг тэр хүмүүстэйгээ дандаа хамт ажиллаж байсан хүмүүс. Тэгэхээр чинь энэ чинь нөгөө бие даасан байдал гэдэг чинь яг энэ хангагдаад байгаа юм уу, хангагдахгүй байгаа юм уу? Яг үүнтэй холбоотой 3 дахь асуулт. Сая түрүүн Цэлмэн гишүүн дурдчихлаа. ХЭҮК-оос бие даасан хараат бус байдлаар ажилламаар байна. Хэт ХЭҮК-ын хараат байна гэж байна. ХЭҮК чинь өөрөө бие даасан хараат бус байгууллага биш юм уу? Энэ чинь ямар учиртай юм бэ? Дахиад хараатын хараат бус байгууллага байгуулна гэсэн үг юм уу? Ерөөсөө наад логик чинь ерөөсөө ойлгомжгүй байгаад байх юм. Тэгэхээр энэ дээр нэг хариулт авмаар байна.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Тайлан бол үр дүнд суурилсан хэлбэрээр жилийн жилд бичигдэж яваа. Үүнийг 2022-2023, 2024, 2025 онуудад хийсэн ийм байдлаар бичиж танилцуулдаг. Үндэсний урьдчилан сэргийлэх ажиллагааны 4 чиг үүрэг байгаа. 4 чиг үүргийнхээ хүрээнд гарсан нөлөөллөөр хийсэн ажил, үр дүнгээ бас тайлагнаж байгаа. Гол үр дүнгийн асуудал бол Хууль зүйн байнгын хороонд танилцуулж хэлэлцүүлж Их Хурлаар бас шийдвэрлэхээр тогтоолд оруулдаг энэ саналуудын асуудал бас байна. Хяналт

шинжилгээ хийдэг хуультай. Хяналт шалгалт хийдэггүй. Тэгэхээр гомдол мэдээллийг хүлээж авах нь одоогоор иргэн, байгууллага, албан тушаалтан, иргэн болон төрийн байгууллага албан тушаалтанд гомдол гаргаж шийдвэрлүүлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу ирсэн гомдлуудыг авч бид түрүүний хэлсэнчлэн эрүү шүүлтийн шинжтэй байх юм бол харьяалах газар нь шилжүүлж байгаа. Мөн өөр бусад төрлийн байх юм бол хуулийнх нь хугацаанд шалгах эрх бүхий байгууллагад нь шилжүүлж ажилладаг. Үндэсний ажиллагаа байгуулагдсанаас хойш 4 жилд 230 гомдол ирсэн. Энэ гомдол бол яг шууд иргэдээс эрх чөлөөтэй байгаа иргэдээс гэхээсээ илүү бид нарын хяналт шинжилгээ хийсэн газрууд буюу хорих ангид хоригдож байгаа цагдан хоригдож байгаа хүмүүс голцуу энэ гомдлуудыг ингэж гаргаж өгсөн байдаг. Сүүлийн жил 61 гомдол ирснийг бид нар шилжүүлээд ингээд холбогдох байгууллага нь шалгаад эргээд тухайн иргэндээ хариу өгөөд мөн бид нарт хариу өгснийг тайланд тусгасан.

Хараат бус байдлын асуудал бол угаасаа хоёулаа хараат бус гээд Хүний эрхийн Комиссын тухай хууль дээр заачихсан. Баасанжаргал гишүүн өөрөө сайн мэдэж байгаа. Өмнө нь Хүний эрхийн Комисст та бас тодорхой чиг үүрэгтэй чиг үүргийг мэдэж байгаа учраас энэ дээр Хүний эрхийн Комиссын тухай хууль дээр хоёулаа л бие биеэсээ хараат бус байна гээд заачихсан. Энэ чиглэлээр явж байгаа. Тодорхой асуудлуудыг хэлэлцээд 2024 оны 37 дугаар тогтоол дээр энэ хараат бус байх тухай асуудлаар нэгэнт Их Хурлын тогтоол гараад шийдвэр гарчихсан учраас энэ асуудал бол түүнээс хойш яг тэр тогтоолд заасан асуудлаараа л хэрэгжүүлээч л гэсэн байдалтай явж байгаа. Мэргэжил шаардлагын хувьд Үндсэн хуульд зааснаар иргэн бол чөлөөтэй ажил мэргэжлээ сонгож явах ийм эрхтэй. Энд сууж байгаа хүмүүсээс тал нь бол цагдаагийн багш биш. Яг энэ талд сууж байгаа референт Манлайбаатар цагдаагийн байгууллагад багшаар ажиллаж байдаг хүн. Энэ хүн бол ажил сайжруулах зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 44-д заасан үндэслэлээр сэлгэнээр 2 жилийн хугацаатай ирж ажиллаж байгаа ийм хүн байгаа. Бусад нь бол төрийн захиргааны байгууллагад ажиллаж байсан ийм хүмүүс сууж байна. Комиссын гишүүний хувьд энэ эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хувьд бол тодорхой нэг шалгуур Комиссын тухай хууль дээр байдаг нь комиссын бусад гишүүдээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байсан ийм туршлагатай.

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя. 3 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Тэгээд Комиссын тухай хууль дээр ингээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагатай ийм байх ёстой гэсэн ийм хуулийн заалттай юм байна лээ. Тэгээд энэний сонгон шалгаруулалтад орж өөрөө санал өгч нэр дэвшиж ингээд томилогдоод ажиллаж байгаа. Нэмж тодруулж хэлэхэд бол хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар ахиц дэвшлийг хүснэгтлэн бас үзүүлсэн. Тухайлбал 11 дүгээр хүснэгт дээр хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны чиглэлээр бол бүх тоон мэдээг статистик байдлаар үзүүлсэн. Энэ дээр нэг зүйлийг бас нэмээд хэлчихье гэж бодож байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төсөв анх намайг томилогдоход 163 сая төгрөг байсан. Одоо бол энэ жил 100-аас доош сая руу орсон. Жилээс жилд төсөв маш их багасаж байгаа гэдгийг хэлэх нь зөв байх гэж бодож байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье. 8 номерын микрофон өгье.

Г.Эрдэнэбат: Баярлалаа. Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Эрдэнэбат. ХЭҮК-оос ирүүлсэн тайлан дээр Улсын Их Хурлын Тамгын газар 5 хоногийн хугацаанд дүн шинжилгээ хийгээд үр дүнд суурилсан тайланг гаргах шаардлагатай гэж дүгнэсэн нь үнэн. Энэ ХЭҮК-ын эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх комиссын үйл ажиллагаа өөрөө урьдчилан сэргийлэх гэдэг үгийнхээ агуулгадаа нийцсэн байх ёстой. Хүмүүс бол ихэвчлэн урьдчилан сэргийлэх гэдгийг ирээдүйд болох юмнаас сэргийлэх гэж ойлгоод байх шиг байна. Гэтэл бол энэ бол урьдын явдлаасаа сургамж авч, түүнийгээ засаж, шалтгааныг нь олж арилгах үйл ажиллагаа байх ёстой. ХЭҮК-ын эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх комисс 407 удаа сургалт хийхдээ урьд нь гарсан хэргүүд дээрээ дүн шинжилгээ хийгээд сургалтаа хийвэл энэ өөрөө тэр дараагийн дараагийн хэргүүдээс урьдчилан сэргийлэх ажил болох ёстой.

Тэгэхээр түрүүн Улсын Их Хурлын гишүүд асууж байна. Хэргийн чинь тоо өсөөд ажил чинь үр дүнд хүрэхгүй байгаа юм биш үү гэдэг төлөвлөлт нь үр дүнгүй байгаа учраас бид нар төлөвлөлтөө үр дүнгүй хийснээс болоод тайлан мөн үр дүнгүйгээр ингэж гараад байна аа. Тийм учраас ажлаа төлөвлөхдөө үндсэн зорилгодоо нийцүүлээд тэр эрүү шүүлтийнхээ учир шалтгааныг судалсан. Тэгээд түүнийхээ яг учир шалтгааныг арилгахад чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлууд, зохион байгуулалтын ажлууд хийгээч. Тэгээд ингэвэл тайлан үр дүнд хүрнэ гэсэн ийм л дүн шинжилгээ хийсэн юм. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороод зөвлөмж өгсөн. Монгол Улсын нөхцөл байдалтай холбогдуулаад зөвлөмж өгсний дагуу төлөвлөгөө гаргаад хийвэл үр дүн нь тэр зөвлөмжийн дагуу төлөвлөгөө хийвэл үр дүн нь гарна.

Хөтөлбөрөө боловсруулахдаа яг тэр асуудалтай байгаа байгууллага нэгжүүдтэйгээ хамтраад ямар асуудал ийм проблем үүсгээд эрүү шүүлтийн нөхцөл байдал үүсгээд байгаа юм бэ гэдгээ хамт ярилцаж байгаад сургалтын хөтөлбөрөө боловсруулж олон талт хамтын ажиллагааны үндсэн дээр хөтөлбөрөө хийгээд тэдний хэрэгцээнд нийцсэн сургалт хийвэл үр дүн гарна. Тэр өргөдөл гомдлоо шийдвэрлүүлэх эрхийг хангах хүрээнд оролцогч байгууллагуудын тэр мэдээллийг нь нийтэд ил тод болгоод тэгээд түүнийг нь шийдвэрлэх ийм системийг нэвтрүүлбэл үр дүн гарна. Ялангуяа хорих байгууллага, цагдан хорих, албадан саатуулах газар, сэтгэцийн ЭМТ хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар энэ сургууль дотуур байранд эрүү шүүлтийн нөхцөл байдал үүсгээд байгаа орчныг арилгахын тулд ажил төлөвлөж түүнд нь хөрөнгө оруулалтыг хийж өгөх юм бол өөрөөр хэлбэл эрүү шүүлтийн шалтгаан болоод байгаа нөхцөлийг арилгах юм бол үр дүн гарна аа. Ийм учраас энэ үр дүн.

Д.Цогтбаатар: Эрдэнэбат дарга яах вэ нэмэх үү? Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Энэ 11 дүгээр хүснэгтийг хараад сууж байна л даа. Тэчнээн сургалт хийсэн, сургалтад хамрагдсан хүний тоо, тэчнээн мэдээлэл түгээсэн, тэчнээн цуврал олон нийтэд мэдээлэл өгсөн гэдэг ийм тоонууд байгаа байхгүй юу. Энэ чинь өөрөө ямар үр дүнд хүргээд байгаа юм бэ гэдгийг чинь л асуугаад байгаа гэсэн үг. Тийм тоо ерөөсөө байхгүй байна. Тэр тоогоо гаргаж сураач. Тэр тоо руу нь чиглэсэн байдлаар бид нар тайлан авмаар байна аа. Тэрнээс биш энэ байгууллагын мянган сургалт хийнэ үү, 2 мянган сургалт хийнэ үү бид нарт хамаа байхгүй шүү дээ.

Тэр мянган сургалт, 2 мянган сургалт чинь л үр дүнтэй байх ёстой. Ямар үр дүнтэй юм тэрийг нь тодруулаадахъя гэсэн үг.

Хоёрдугаарт гол асуух гээд байгаа юм юу байна? Бие даасан хараат бус байдал гэдгээ та нар яг юу гэж ойлгоод байгаа юм бэ? ХЭҮК-оос бие даасан хараат бус байна гэж ойлгоод байгаа юм уу? Комисс чинь өөрөө бие даасан хараат бус байгууллага биш юм уу? Би ерөөсөө тэрийг чинь ерөөсөө ойлгохгүй юм. Бие даасан хараат бус байгууллагаасаа дахиад тусдаа бие даасан хараат бус байгууллага байна гээд байгаа юм уу, яг юугаа хэлээд байгаа юм гэдгээ тодорхой хэлээдхээч.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Манай тайлангийн бүлэг тус бүр дээр тодорхой хүрсэн үр дүн дүгнэлтээрээ байж байгаа. Тэгэхээр энийг тодорхой бас товч утгаар ямар үр дүнд хүрсэн бэ гэдгээ харуулсан. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнгийн хамгийн чухал хэсэг бол энэ олон хяналт, шинжилгээ, сургалт нөлөөллийн арга хэмжээний дараа хүргүүлдэг энэ зөвлөмж байгаа. Мөн өнөөдөр хэлэлцүүлж байгаа тайлан хэлэлцүүлээд түүнээс гаргаад Их Хурлаар гаргуулж байгаа шийдвэр бол хамгийн үр дүнд хүрсэн ийм поинт гэж бид нар хардаг. Олон улс ч тэгж зөвлөдөг. Бид нар дээр хэрхэн хяналт шинжилгээ хийж ажиллах талаар төлөвлөгөөн дээр Эрүүдэн шүүхийн дэд хороо, Хүний эрхийн олон улсын эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг бол 4 дэх жилдээ хамтарч ажиллаж байгаа.

Монгол Улсын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа бол бүс нутагтаа тэргүүлсэн жишиг туршлага тогтоолоо гэдгийг 2024 онд тусгайлан тэмдэглэсэн НҮБ-ын хуралдаан дээр. Өнгөрсөн жил мөн стратеги төлөвлөгөөтэй ажиллаж түүндээ.

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя.

Я.Цэлмэн: Тэгээд тодорхой энэ стратеги төлөвлөгөөтэй ажиллаж түүндээ хүрэхээр зорьж ажилласан нь бол энэ эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх буюу олон улсад үндэсний урьдчилан сэргийлэх механизмынхаа зорилтод нийцэж байна гэж ингэж дүгнэсэн байгаа юм аа.

Хүний эрхийн Комиссоос хараат бус байна гэж би ерөөсөө яриагүй байгаа. Хүний эрхийн Комиссын тухай хууль дээр Хүний эрхийн Комисст 2 механизмыг хуульчилсан байгаа хууль дээр нь нэг нь Хүний эрхийн Комисс нөгөөдөх нь эрүүчлэлээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа гээд. Тэгээд тодорхой хуульчилчихсан хоёулаа хараат бус бие даасан байна гээд дотор нь 2 төсөв байгаа. Хоёулаа төсөвтэй байна гээд. Тэгээд бие биеэ хүнээ томилоод тус тусдаа томилоод явна гээд ингээд та бүхний баталсан хуульчилсан зохицуулалтыг л би дагаж мөрдөж хэрэгжүүлж ажиллаж байгаа.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Түрүүн тасалчихлаа.

П.Сайнзориг: Гишүүддээ бас өглөөний мэнд хүргэе. Би энэ Цэлмэн гээд нөхрийн энэ хариултыг бүр ойлгохгүй байна. Би энэ хүний эрхийн үндэсний эрүүдэн шүүлтийн механизмыг би өөрөө бий болгохын төлөө энэ хуулийг нь боловсруулж

батлуулсан байхгүй юу ХЗДХЯ-нд. Энэ хууль дээр тийм үг үсэг байхгүй. Чиний хувийн хандлагаас болж байгаа. Чи энэ хувийн хандлагаасаа болж энэ байгууллагыг тусдаа оффистой болгож байгаад тусдаа төсөвтэй болгоод тусдаа энэ дан хүмүүсийг томилъё гээд явж байгаа. Энэ комиссын зүгээр нэг нэгж байхад болох юм. Энэ үйл ажиллагаан дээр нь хараат бус байгаа болохоос биш бусад тэр захиргаа болон бусад юм нь нэг байх ёстой байхгүй юу. Ингээд төрд данхайлгаад чиг үүрэг давхцуулаад бүх гишүүдэд ингэж худлаа үнэн мэдээлэл яваад улам монголчлох гээд байгаа байхгүй юу. Бид хэд харин энэ байгууллагын нэгжийн өгч байгаа энэ зөвлөмжийг Улсын Их Хурлын дэргэдээс байгуулагдаж байгаа байгууллага байгуулсан учраас бид анхаараад зөвлөмжийг яаж хэрэгжүүлэхийг, Засгийн газар болон бусад байгууллагадаа үүрэг даалгавраа өгөх юм. Энийг ХЗДХЯ-ны дэргэд ч байгуулж болох байсан хувилбар нь. Тэгэхдээ энэ өөрөө эргээд бас зохимжгүй юм гээд энд байгуулсан чинь энэ нэг цагдаа стилистэй нөхөр бүх зүйлүүдийг зүгээр эрх мэдэл гээд ойлгочихсон. Энд худлаа хэлээд чи зүгээр дарвалзаад байгаарай Цэлмэг ээ.

Та нарын баталсан хуулийг чинь яаж байна аа? Чи хуулийг мушгиж ингэж тайлбарлаж болохгүй юу? Тийм учраас энэ гишүүд ч гэсэн энэ буруу зөрүү мэдээлэл аваад ингээд өөгшүүлээд энэ сүүлдээ энэ байгууллага чинь бүр сонин тогтолцоогоор ажиллаж байна лээ шүү дээ. Комиссын байр руу ажилчдаа орохоор халж байна лээ энэ нөхөр. Ийм хэмжээнд ингэж төрийн ажилладаг механизмыг ингэж буруу ашиглаж ийм зүйл хийж болохгүй ээ.

Би тэгээд үндсэн асуудал руугаа орьё. Энэ прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба гэж байгаа юм аа. Яах вэ бид хэд энэ алдаа оноог нь бас үзчихсэн. Уг нь бас ашиглавал үр дүнтэй байж болох. Тэгэхээр энийг яах вэ зүгээр өмнө нь бас нэг оруулж ирээд бас дэмжигдээгүй ийм асуудал байгаа. Эсвэл Мөрдөх албаны тогтолцоо руугаа яг орох асуудал байгаа юм. Үнэхээр өнөөдөр цагдаагийн байгууллагын томилгооноосоо эхлээд энэ улс төржчихлөө шүү дээ. Улс төрийн албан тушаалд нэг цаг байтугай нэг өдөр ажиллаж болохгүй байж байхад улс төрийн албан тушаал дээр ажилласан хүнийг өнөөдөр хуулийг нь зөрчөөд цагдаагийн байгууллагын даргаар тавьчихсан байна. Энэнээс чинь эхлээд эрүү шүүлт явна за юу. Энийг ингээд дүгнэж гаргаж ирэх ёстой юм. Энийг энэ Хууль зүйн сайд нь ХЗДХ-ийн дэд сайд нь ингээд буруу ард түмнээр тохуурхаад зогсож байгаа юм. Ийм байхаар чинь наад эрүү шүүлт болон улс төрөөс ангид байх энэ хэрэг маргаан шийдэх юм чинь юу болох юм. Би ойрын өдрүүдэд бас энэ нөхцөлүүдийг чинь биеэрээ амсчхаад сууж байгаа юм.

Намайг энд байж байхад орон гэр дээр очиж ар гэрийг айлгаж байгаа шүү дээ хаалга нүдээд. Тэгээд ийм бичлэг хийгээд баталгаажуулаад гэртээ байгаагүй гээд, дараагийн арга хэмжээ авах гээд. Ингээд нотлох баримтуудыг бүрдүүлээд хавтаст хэрэгт наадаг юм байна лээ. Ерөөсөө л нэг ийм хөгийн үйлдэл.

Д.Цогтбаатар: Минут нэмж өгье.

П.Сайнзориг: Тэгэхээр ер нь Засгийн газар бид хэд энэ дээр энэ тайланг үндэслээд ажлын хэсэг гаргаад манай Эрдэнэбат прокурор сууж байх шиг байна. Прокурор гээд би хэлчихлээ дэд дарга болчихсон юм байна. Энэ асуудалд сайн муугаараа санаатай санаагүйгээрээ холбогдохсон бас. Тэгэхээр энийг бас засах энэ хүнд академик мэдлэг байж байгаа. Тэгээд гишүүд гаргаад дэд ахлах юугаар нь Эрдэнэбат прокурорыг тавиад ч юм уу тодорхой Засгийн газарт бас чиглэл өгсөн

энэ асуудлыг нэг шийдмээр байна. Мөрдөх албаны тогтолцоогоо оруулж ирэх юм уу, ирэхгүй юм уу. Тэгээд өнөөдөр ярьдаг гайгүй боловсролтой мөрдөгч нарыг шууд дур нь хүрэхээрээ замын цагдаа болгочихдог. Өөрийнхөө гар хөл болгож шууд удирдлагаар хэрэг боодог хүмүүсийг дэргэдээ ингэж авч ажиллуулж байна шүү дээ. Тэгэхээр бид хэд энийг ингээд хууль сахиулах реформыг хийе ээ. Дандаа улс төрөөс нь болоод ингээд хойш суугаад байж болохгүй.

Тэгэхээр энийг би 1 дүгээрт зайлшгүй хийх ёстой.

Хоёрдугаарт энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ял хариуцлага байгаа. Энэ чиглэлдээ ял хариуцлагыг яахгүй бол цагдаагийнхан болон мөрдөх албаныхан.

Д.Цогтбаатар: Ямар ч гэсэн эхний хэсэгт Цэлмүүн хариул. 3 дугаар микрофон.

Я.Цэлмэн: Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

ХЭҮК-ын тухай хуулийн 3.1.2 дээр бол яг 2 байгууллагын ялангуяа эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны талаар хараат бус байдлыг нь бэхжүүлж өгсөн. 3.31.2 гээд 31.3 гээд мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулах баталгаа нөхцөлийн талаар хуульчилж өгсөн. Тэгэхээр энэ яг хууль болон нэгдэн орсон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын хүрээнд яах вэ бид нар үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа. Гол асуудал бол Мөрдөх алба байгуулах бол маш их шаардлагатай байгаа. Мөрдөх алба байгуулах тухай асуудлыг 2023 онд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас бас санал болгосон. Их Хурлын тогтоол 35 дугаар тогтоол дээр Засгийн газарт байгуулах эсэхийг судалж танилцуул гэсэн. Өнгөрсөн оны 2025 оны 7 сарын 8-ны өдрийн 77 дугаар тогтоол дээр Засгийн газарт байгуул гээд үүрэг болгочихсон. Эрүү шүүлт тулгах эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг бол мөрдөх шаардлагатай гээд байгуулах шаардлагатай гэж үзсэн.

Хэвлэлээр бол түрүүлж мэдээлэл цацах эргээд энэндээ хуулийн байгууллагууд хариуцлага хүлээхгүй байгаа энэ асуудлыг тодорхой хуулийн зохицуулалт бол гаргах нь зүйтэй байгаа. Ялангуяа энэ мөрдөн шалгах ажиллагааны нууцлалтай холбоотой асуудлын зохицуулалт бол өөрөө бас их ийм тодорхойгүй байгаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Уг нь сая авчихсан шүү дээ гэхдээ тэгье тэгье. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Ер нь манайд нөгөө хэргийн оролцогчдыг айлгаж гарын үсэг зуруулаад хэргийн материалаа хамгаалж байгаа. Бусад оронд бол энэний эсрэг болчихсон байна аа. Мөрдөгч, прокурор, шүүгч байдаг юм уу? Энд мэргэжлийн яг оролцогч бол энэ хүмүүс хэргийн материалыг задлах байдлаар хэргийн нөхцөл байдлыг бодит үнэнийг тогтоох үйл ажиллагаанд саад учруулах бол эсвэл десторшн хийх энэ оролдлогууд дээр маш том хэмжээний хариуцлагуудыг оногдуулж байна. Тэгэхээр энэ чиглэл рүүгээ явахгүй байж байж өөрсдөө ингээд ашигтай байдал буюу тандалтаа хийгээд ингэж байгаад оруулчихвал угаасаа нийгэм хүлээгээд авчихна гэдэг байдлаар ийм арга барилуудыг өнөөдөр өөрчлөх цаг болжээ. Тэгээд Солонгос

хамгийн сүүлд реформ байна. Би тэгэхдээ тэрийг сайн гэж байгаа юм биш. Энэ легал десторшин хийж буюу бодит байдлыг мушгиж энэ бодит эрх зүйн энэ зарчим энэ зохицуулалтуудыг мушгиж хэргийг хүлээлгэх энэ хэргийг шийдэж байгаа энэ мэргэжлийн оролцогчдодоо илүү их чанга хариуцлага хүлээлгэж байж бас шударга ёс тогтох юм байна гэж явж байна.

Тэгэхээр энд Мөрдөх алба болон хууль сахиулах.

Д.Цогтбаатар: Асуулт асууя гэсэн юм уу? Ганбат гишүүн би бол ингэлээ шүү. Соронзонболд гишүүн яах юм асуух юм уу? Тэгвэл ингэе. Би Соронзонболд гишүүнд өгье. Гэхдээ би нэг зүйлийг хэлмээр байна. ХЗБХ тэргүүн ээлжид өөрөө хуулиа сахиж байх ёстой. Энэ ингээд асуулт асуух боломжгүй энэ чинь бусад гишүүдтэй аягүй бас шударга бус болж байгаа байхгүй юу. Тэгэхлээр цагтаа ирээд л асуултаа юу яачихсан байхад чинь тийм. Тэгэх үү Соронзонболд гишүүн ээ? Тэгье би гишүүдийн юугаа тэгвэл дагалаа шүү. Одоо энэ хэлэлцэж байгаа тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

С.Соронзонболд гишүүнээр тасаллаа. Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Д.Цогтбаатар: Асуулт хариултуудыг бас сонслоо. Тэгээд гол нь зүгээр ямар ч ажил хийж хэрэгжүүлсэн бай үр дүн чухал л байгаа юм л даа. Өнөөдөр энэ татвар төлөгчдийн мөнгөөр л цалин хангамж аваад л үйл ажиллагаа явуулаад байдаг. Гэтэл ингээд сүүлд нь ажлын үр дүнг нь харахаар үр дүн буурсан үзүүлэлттэйгээр орж ирээд байдаг. Тэгээд энэ дээр яг яах ёстой юм? Тэр эрх мэдэл чиг үүргийн хуваарилалт чинь дараагийн сэдэв байж болох байх. Тэр нь ч багадаа ч үгүй байх. Тэгээд тэр хараат бус байна уу? Хараат байна уу? Хүний эрхийн Комисс бол үйл ажиллагаа нь хараат бусаар явагддаг байх. Тэгэхдээ Их Хурлын дэргэдэх л байгууллага л даа. Тэгэхээр Их Хурлын дэргэдэх байгууллага гэдэг бол цаашлаад энэ гүйцэтгэх засаглал, түүний харьяа агентлаг, салбар байгууллагуудын үйл ажиллагаанд л хяналт тавих эрх нь үүсэж байгаа юм л даа. Угаасаа чиг үүргээр. Тэгээд энийгээ хэрхэн хэрэгжүүлж явдаг юм бэ гээд.

Сүүлийн үед энэ чиг үүрэг холилдож яваад байгаа тохиолдол их олон тохиолдоод байгаа юм. Шууд иргэнд үйлчилдэг байгууллага биш гэдэг агуулгаараа энэ чинь Их Хурлын дэргэдэх байгууллага хяналт тавьдаг статустай байхгүй юу. Их Хурлын нэрийн өмнөөс чиг үүргээр. Тэгээд энийгээ хэрхэн хэрэгжүүлж байгаа юм бэ гэдэг талаар л би асуудал яриад байгаа юм. Нэг нь асууж, нэг нь хариулсан болоод асуудалд битгий хандаач ээ. Илүү үр дүн гаргая аа. Энэ эрүүдэн шүүлт буурч энэ хүний эрх зөрчигдөхгүй байх нөхцөлийг хууль эрх зүйн орчин ч тэр практик нөхцөл байдал дээрээ ч тэр бууруулах л энэ асуудлыг л яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр соён гэгээрүүлэх ажлаа хэрхэн чиг үүргийг нь яаж хийх юм? Газар дээр нь очиж нөхцөл байдлыг арилгах тал дээр хэрхэн яаж ажиллах юм гэдэг асуудлуудаа л танай байгууллага энэ дээрээ илүү анхаарах ёстой юм болов уу л гэсэн тийм шүүмж байна. Та хэд маань бас үйл ажиллагаандаа тусгаж аваад явбал уул нь. Тэгэхгүй бол тэгээд ингээд нэг нь нэгэнтэйгээ ингээд эрх мэдэл булаацалдаад байгаа ч юм шиг сөргөлдөөд байгаа ч юм шиг ийм нөхцөл байдлаар асуудалд хандаад байвал энэ чинь дунд нь энэ ажил орхигдоод байгаа байхгүй юу. Тэгээд энэ Улсын Их Хурлын гишүүдийн уурлаж байгаа бас буруу биш шүү дээ.

Ер нь ингээд энэ үг хэлээ бас нэг жоохон асуудалдаа бид нар анхаарах ёстой. Та хэд хэдэн удаа өнөөдөр үгийн алдаа гаргалаа шүү дээ. Улсын Их Хурлын баталсан тогтоолыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж бодож байгаа. Та нарын баталж өгсөн хуулийг иймэрхүү чиг байдлаар бас хандлагын асуудал бас энэ алдаа дутагдал гаргаж болохгүй гэдгийг бас тэр тусмаа та нар хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг энэ эрүүдэн шүүлтийг бууруулах нөхцөл дээр бас бодлого гаргаж ажиллаж байгаа байгууллага юм бол өөрсөд дээрээ эхлээд энэ асуудал дээрээ бүүр анхаарах зайлшгүй шаардлага байгаа юм байна гэж бодож байна.

Тэгээд дараа жил өдийд орж ирэх тэр тайлан дээр бас арай нэг ахиц дэвшилтэй өөр зүйл орж ирэх байх гэдэг хүлээлт үүслээ. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Ноднингийн тайлан дээр бас яг энэ үгийг хэлж байсан юм. ХЭҮК эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх энэ чиг үүрэг парламентын хяналтыг бие даасан байдлаар хэрэгжүүлж байгаа эженси буюу энэ хүрээнд байгаа шүү. Тэгснээс биш эрх мэдэл хуваарилалт болон Үндсэн хуулийн дэг журмаасаа халиад гадна ямар нэгэн институт байгуулаагүй шүү. Хараат бус байна гэдэг нь гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус байх тухай яриа шүү. Тэгсэн болохоос биш тэр байгууллагынхаа дотор эрх мэдлээ хуваарилж хил хязгаар тогтоох тухай ерөөсөө яриагүй. Монгол Улс ХЭҮК гээд комиссын системийг сонгочихсон омбудсмений тогтолцоо сонгосон байсан бол чиг үүргээр нь тус тусад нь омбудсмен томилж өгч болох байсан байх. Тэгэхээр энэ тогтолцооны ялгаа энэ тэрээ бид на бас харж ярьж байхгүй бол зүгээр хувийн бодлоороо хил хязгаараа даваад явж болохгүй. Саяын дүгнэлт дотор байгаа хамгийн чухал нэг 2 зүйл бол ХЗБХ энэ дээр анхаараад Засгийн газар шаардах хэрэгтэй юм байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2024-2028 оны 4.2.1.14 дээр гэрч хохирогчийг хамгаалах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагаа ажиллагааг шинэ шатад гаргана гээд бүүр мөрийн хөтөлбөр дээр нь заачихсан. Одоо энийгээ бид нар хэрэгжүүлэхийг Засгийн газраас бүүр хатуу шаардаад энэ жилдээ бүүр амжуулж гаргамаар байна. Эрүү шүүлт тулгаж байгаа гэмт хэргийн чинь дийлэнх нь энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг байхгүй юу? Хэрэг өөрөөр хэлбэл гэмт хэрэгтэй тэмцэж байгаа мөрдөн шалгаж байгаа байгууллагууд өөрсдөө гэмт хэрэг хийгээд байвал энэ гэмт хэргийг нь шалгадаг тусдаа бүтцийг Засгийн газрын дотор байгуулж өгөхгүй бол болохгүй байгаад байгаа юм. ХЭҮК буюу энэ Цэлмэнгийн хийж байгаа ажил бол гадаад хяналт явж байгаа юм.

Засгийн газрын дотоод хяналтыг байгуулаагүй учраас одоо энэ Засгийн газар чинь ямар ч хүний эрхийн мэдрэмжгүй, алдаагаа засаж чаддаггүй, нэг мухар гудамж руу толгойгоо шаагаад цаашаа мөлхөөд байдаг л бүтэц болчихоод байгаа юм. Бүүр том сонирхлын зөрчил нь бид Хууль зүй, дотоод хэргийн яамаа салгах ёстой байхгүй юу. Хууль зүйн яам чинь Дотоод хэргийн яамаа Засгийн газрын дотоод хяналтаар хянаж байх ёстой гол бүтэц нь шүү дээ. Гэтэл өөрөө сонирхлын зөрчилтэй болчихсон. Хууль зүйн сайдууд нь дотоод хэргийн чиг үүрэг дээрээ мордчихсон. Тэгээд сонирхсон зөрчлөөсөө болоод авлига хээл хахуулийн хэрэгт холбогдоно. Эрүү шүүлтийг халхалж хамгаалах, цагдаагийнхаа талд зогсож эс үгүй

бол энэ мөрдөн шалгах буюу гэмт хэрэг хийж байгаа байгууллагуудынхаа өмгөөлөгч нь болоод ингээд суучхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийг бид нар яаж засах юм? Одоо зоригтой ярих ёстой. Хамгийн гол нь энэ Мөрдөх алба биш шүү. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1.50 дээр 8 дээр байж байгаа. Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлэх мөрдөх алба байгуулах тухай. Энэ мөрдөх алба нь өөрөө гэмт хэрэг мөрдөн шалгах үйл ажиллагаагаа хууль бусаар хийгээд байвал энийг нь шалгадаг байгууллага байгуулах тухай нь саяын дараагийнх дээр нь байж байгаа байхгүй юу. Одоо бид нар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг үйлдээд байна. Мэдээллээ өөрсдөө задлаад байна, хэвлэлээр хүнийг буруутгаад байна, нотлох баримтаа хуурамчаар бүрдүүлээд байна аа. Зохиол бичиж байгаад эрүү шүүлт тулгаж байгаад хүн хэлмэгдүүлэх тогтолцоо ажиллуулаад байна аа. Нөгөө Вишинскийн онол чинь амьд байгаад байна гэх мэтчилэн ийм зүйл ярьж байгаа бол энэ зүйлийг мөрддөг байгууллага байгуулах тухай ярьж байгаа.

Парламентын хяналтыг хэрэгжүүлж байгаа байгууллага мөрдөж чадахгүй шүү дээ. Угаасаа энэ гүйцэтгэх эрх мэдэл гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэхгүй. Засгийн газарт энэ байгууллагаа байгуулах тухай.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Одоо бид Засгийн газрын ажлыг урдуур нь хийх тухай биш. Засгийн газар энэ төрлийнхөө ажлыг хийж чадахгүй юм уу, чадах юм уу гэдэг дээр нь бүүр Улсын Их Хурал дээр авчирч байгаад энэ үйл ажиллагааны хөтөлбөр дотор орчихсон байгаа энэ заалтуудаа хэрэгжүүлэх юм уу, үгүй юм уу гээд. Учрал сая Ерөнхий сайдаар томилогдсон. Улсын Их Хурлын дарга байхдаа хэлсэн үг нь байгаа.

Гэрч хохирогчийг хамгаалах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг үйлдэж байгаа энэ үйлдлийг таслан зогсоохын тулд буцаагаад энэ шүүхийн аюулгүй байдлыг хангах, шүүн таслах үйл ажиллагаа хэвийн нөхцөлийг хангах энэ нотлох баримт болон олон зүйлийг хуурамчаар үйлдэж байгаа энэ үйлдлийг таслан зогсоохын тулд энэ байгууллагыг байгуулах ёстой юм байна гэдэг үг хэлсэн. Хэлсэн үг нь сарын өмнө бараг шүлс нь хатаагүй байна. Шинэ Ерөнхий сайд манлайлал гаргаад энэ асуудлаа шийдэх байх гэж би итгэж байгаа.

Хууль зүйн байнгын хороо энэ дээр манлайлал гаргаад шахах ёстой. Ажлын хэсэг байгуулаад шаардаад хуулийн төслөө хэдэн сарын дотор өргөн барих юм.

Д.Цогтбаатар: Яг үнэн энэ дээр Тэмүүжин гишүүн бүүр тусгайлан ярьж энэ асуудлыг хөөцөлдөөд та яваач. Би ч энэ дээр дэмжээд яг үнэн ХЗБХ энэ дээр манлайллаа гаргах ёстой. Тэгээд энд 27 гишүүн сууж байгаа. Иймэрхүү юмнууд дээрээ бид нар засгаа шаардаад чиглүүлээд өөрсдийнхөө бодлого ийм байна аа. Энэ юмаа хийх ёстой гээд юу шаардлагаа тавиад явах ёстой шүү, энэ чинь л хяналт.

Тэмүүжин гишүүн яг энийгээ хариуцаад ер нь явна шүү. Хоёулаа энийг жич тэгвэл ярих нь зөв юм байна.

Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Сая Их Хурлын гишүүдийн ярьсан зүйлээс үүдээд бас Сайнзориг гишүүн ч хэлж байна. Ингээд улс төрийн зорилготой ийм зүйлүүд их гарч байна гэж. Тэгэхээр энэ бүх зүйлийг ер нь ингээд хараад байхад Монголын нөхцөл өнөөгийн нөхцөл байдлыг ч гэсэн энэ хараад байхад эрүүдэн шүүхийн энэ урьдчилан сэргийлэх энэ үндэсний үйл ажиллагаа нь бүүр хараат бус байх зайлшгүй шаардлагатай юм байна л гэж би бүүр тийм дүгнэлтэд хүрч байна. Үгүй 1 наймхан хүн тэндээ вант улс байгуулаад юу шалих вэ дээ. Наймхан хүний тэр байгууллагын төсөв мөнгө тэнд чинь юуг зарцуулаад шалих вэ дээ. Гэтэл энэ улс төрд чинь хэчнээн тэрбумаар нь хулгайлж байна шүү дээ. Энэ ингээд яг ОУБ-ынхаа заавар зөвлөмжийн дагуу ажиллах гэхээр л Үгүй нэг 8 хүнийг л нэг тэр нь дарга болох гэлээ. Энэ нь ингэлээ гээд аз үзээд. Та нар тэрийгээ больчооч.

Нэг Монголчилдог коммунистчилдог юмаа болих хэрэгтэй шүү дээ. Энэ чинь ОУБ нь ингээд ийм зөвлөмж өгч байхад энүүгээр нь л ажиллуулах ёстой. Харин улс төрдөд энэ чинь хамгийн хэрэгтэй юм байхгүй юу? Захиалгаар, эрүүдэн шүүгээд, улс төрийн захиалгаар эрүүдэн шүүх гээд байхад энэ хүмүүс чинь хараат бус бүх юмыг нь зөвлө ОУБ-даа мэдээлээд энэ чинь дэлхий дахинд шүгэл үлээх ийм боломж гарч ирж байгаа байхгүй юу. Тэгээд л нэг ганц нэг бензинийх нь зардлаар нэг цалингийнх нь зардлаар ингээд нэг дарамталдаг ийм юм болохоор чинь явдаггүй юм аа. Би тэр комиссаруудтай чинь зөндөө уулзаж байсан юм.

Тэгэхээр ингээд нэг юмыг Монголчилдгоо боль. Тийм л мундаг байсан юм юм бол саяхан хүртэл шүүхийн шийдвэргүй 99 хувь баривчилдаг л байсан шүү дээ. Хэн дуртай нь очоод л баривчилдаг л байсан шүү дээ. Тэгээд НҮБ-ынхан ирээд шүгэл үлээгээд Монгол Улс чинь 99 хувь нь шүүхийн шийдвэргүй баривчилдаг юм байна гээд бид Хүний эрхийн Комиссынхонтой ажиллаж байж байж энэ ОУБ-тай чинь хамтарч байж энэ хуулийг нь өнгөрсөн парламентад өөрчилсөн шүү дээ. Энэ шүүхийн шийдвэргүй баривчилгааг чинь зогсоосон шүү дээ. Тэгээд бүх юм нь сайхан байсан юм шиг та нар битгий ингэж энэ яг энэ конвенцынхоо дагуу ажиллах гээд байгаа хүмүүсийг ингэж дарамталж бай. Тэгээд дарамтлаад загнаад байхаар энэ хүмүүс чинь сүүлдээ асуултдаа ч хариулж чадахгүй. Энэ тайланг нь нэг ч гишүүн уншаагүй л байна шүү дээ. Гишүүд унш л даа тэгээд сургалт хийсэн үр дүн гээд байх юм. Сургалт чинь ирээдүйдээ үр дүн нь гардаг болохоос сургалт хийчихсэний маргааш үр дүн юу гэж харагдах юм. Тэр чинь 5 жил, 10 жил, 20 жилийн дараа л нөлөөллийн ажиллагааны чинь үр дүн гарна шүү дээ.

Тийм болохоор одоо бас энийгээ яг олон улсын юугаараа явах ёстой гэж би бол хатуу хэлэх гэж байна.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Тэгээд өөр өөрийнхөөрөө хэлж байна аа. Харин Одонтуяа дарга маань бас зөв мэдээлэл аваасай. Улам Монголчлох гээд байх хэрэггүй. Комисс гэдэг чинь өөрөө бид нарын Улсын Их Хурлаас байгуулж өгсөн хараат байгууллага байхгүй юу. Энэ комиссын нэг хэсэг л юм. Загвар нь энэ юм. Гэтэл энэ нөхөр өнөөдөр үйл ажиллагаа энэ эрүүдэн шүүлтийн гол агуулга руугаа орох биш. Хүн нэмж өг 35 хүн, төсөв нэмж өг. Төсвийг нь өгнө өө хангалттай байх ёстой. Байр сав нь тусдаа гарчихсан. Би хэлээд байна шүү дээ Одноо эгч ээ. Энэ мэдээллүүд нь ирж байна аа. Энэ нөхөр алба хаагчдаа ХЭҮК-ын байраар орсон мэдээлэл нь ирвэл шууд халж байгаа. Ийм байдлаар ингэж ажиллаж болохгүй байхгүй юу даа. Энэ чинь

нэг байгууллага. Би энэ өөрөө хуулийн бичсэн олон улсын механизм мэдэж байгаа. Тэгэхээр гол агуулга руугаа ормоор байна аа. Энэ бол бид нарын уг нь одоо жинхэнэ гар дээр мэдээллийг нь тавиад бид энд ямар бодлогын арга хэмжээг авах вэ? Энэ дээр ингэж хуулийг нь өөрчилъе. Энэ дээр ингэж зохион байгуулалттай явъя ингэх ёстой. Орж ирээд л ингээд л дандаа худлаа хэлээд л одоо сүүлдээ энэ хуулийг та нарын яасан юмаар бичээд нэг тусдаа байртай болоод тусдаа төсөв зарцуулах гээд байгаа гэж авч байна шүү дээ. Ингэж бид нар ингэж өөгшүүлж болох юм уу? Гол асуудлаа ярихгүйгээр. Тэгэхээр энэ дээр л хэлсэн шүү.

Хоёрдугаарт, Тэмүүжин гишүүн ч хэлчихлээ дээ, миний тэр санааг. Ер нь энэ ажлын хэсгийг гаргая. Тэгээд олон жил ингээд тойрч явлаа. Тэгээд ер нь тогтолцоо бүтцийн хувьд бас эргэж харах зарим зүйлүүдээ хийх нь зайлшгүй байна аа. Нэг юм ярихаараа ингэж элдэв шалтаг хэлж явсаар байтал энэний чинь цаана жирийн иргэд асар ихээрээ хохирч байна аа. Бид хэд энэ эрүүдэн шүүлтийн гэдэг юм уу энийг гаргахгүй байх мэргэжлийн мөрдөгч нарыг бэлдэх энэ тогтолцооноосоо л эхлэх юм байна лээ. Энэ гайгүй залуучууд явдаг зарчим ярингуут нь ийш тийшээ шилжүүлчихдэг, хөдөө цөлчихдөг, эсвэл өөр нэгж рүү явуулчихдаг. Яг тэгээд үг дуулгавартай ийм хүмүүсийг тэрэн дээр авч хавтаст хэргүүдийг боож байгаа. Тэгээд тэд нар нь бүр улаан цагаан болчихсон. Нэг өдөр л дэвшдэг. Нэг өдөр эрүүдэн шүүлтийн ял уншсан шүүгч өнөөдөр давахын шүүгч болоод л дараа улиралдаа давахын шүүгч болж байна шүү дээ. Ингэж хурдтай кранаар өгсөх энэ зүйлүүд дээр ингээд бий болчихлоо бий болчихлоо. Тэгэхээр ийм зүйлүүдийг зайлшгүй засмаар байна аа. Цагдаагийн дарга нь улс төрийн албан тушаал дээр нэг өдөр байтугай нэг секунд байтугай ажиллаж байгаагүй хүнийг тавья гээд явсан. Монголын цагдаад хүний нөөцөөр дутаагүй шүү. Ерөнхий сайдын зөвлөх байсан хүн нь томилогдож оччихоод тэгээд сүүлдээ хууль зөрчсөн. Тэндээсээ цалин хөлс авч байсан энэ тэр гээд ингээд ард түмнийг, парламентыг доромжлоод сууж байхад ер нь манай парламентын гишүүдээс хэн дуугарсан юм.

Энэ цагдаа хууль сахиулах алба нь улс төрийн бус ингээд нэвширтлээ илжирчхээд байхад хэн дуугараад байгаа юм. Тэгээд энэ бүгд хүлцэнгүй. Бид нар прокурорыг томилоход хүртэл тэгсэн шүү дээ. Нас сүүдэр нь болчхоод байгаа хүнийг л бид хэд бүгд л дуугүй бүлдэгдүүлээд л ингээд л батлаад л явуулсан шүү дээ. Ялангуяа манай ХЗБХ ярих л ёстой байсан шүү дээ. Хэн ярьсан юм? Бүгд дор дороо үр хүүхдүүдийнхээ асуудлыг, өөрсдийнхөө хэргийг наймаалцаад л та хэд дуугүй бүлдэгдүүлээд л байж байсан биз дээ.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн юун бүлдэг мүлдэг яриад явчхав. Би одоо хэнд бүлдэгдүүлчхээд та чинь юу яриад байна? Тийм. Би л лав хэнд ч бүлдэгдүүлээгүй. Өөрийнхөө үгийг одоо та их хурц хурц үг хэрэглээд байна. Тэр үгийг чинь би ил биш далд хэнд ч хэлнэ. Тэгэхээр гишүүд бие биедээ хүндэтгэлтэй хандах ёстой шүү. Тэгээд энэ дээр мэдээжийн хэрэг хэлэх үгнүүдээ хэлэлгүй яах вэ? Гэхдээ бие бие рүүгээ дайраад энэ чинь энэ Байнгын хороо бас нэг ажлаа зүгээр явуулдаг байх хэрэгтэй шүү дээ. Баярмаа гишүүний микрофоныг өгье.

Ж.Баярмаа: Уг нь бол энэ тусдаа конвенцыг зохицуулагддаг үйл ажиллагаа нь ийм байгууллага гэж би уг нь ойлгоод байгаа юм. Энэ нэр нь бол маш тодорхой Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийдэхийн эсрэг конвенц гээд. Тэгээд энд манайх аль 2022 онд элссэн юм уу? Тэрнээс хойш нэмэлт протоколд нь элсээд ингээд яваад байгаа гээд тэгэх юм бол тэгээд энийг ингээд уншихаар энэ конвенцын байгууллага энэ ОУБ нь

өөрөө зөвлөмж өгөөд байдаг юм байна шүү дээ удаа дараа. Тэгээд энэ зөвлөмжийг нь ингээд үзэхээр бие даасан хараат бус үйл ажиллагаа явуулах ёстой гээд энүүгээр дүүрэн ингээд биччихсэн байгаад байна л даа. Удаа дараагийнх нь зөвлөмжид. Тэгэхээр энэ байгууллага чинь одоо бие дааж хараат бусаар ажилла гэж хэлээд байгаа энэ зөвлөмж нь ХЭҮК-оос тусдаа бие дааж тусгаар байдлаар ажилла гэж зөвлөөд байна гэж би ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд бид нар маш их ойлголтын зөрөөтэй юм байна л даа. Зарим гишүүд болохоор энэ чинь яг нэг байгууллага нэг дотроо байж байх ёстой гээд байгаа юм.

Хоёрдугаарт энэ Улсын Их Хурал маань өөрснөө асар олон тогтоол гаргажээ. Нийт 5 тогтоолын биелэлтийг дүгнээд 45.8 хувь буюу хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэсэн юм байна.

Тэгэхээр энэ Улсын Их Хурлын тогтоолууд чинь бараг хэрэгжихгүй байгаад байна. Тэгэхээр энэ тогтоолууд яагаад хэрэгждэггүй юм бэ? Хэрэгжих ёсгүй эсвэл буруу тогтоолууд гарчихсан юм болов уу? Би бас гайхаж байна л даа өдий хүртэл. Тэгээд тэрэн дотор нь энэ бие даасан байдалтай холбоотой бас зүйл заалтууд байгаа гэж би ойлгоод байгаа. Тэгээд хэрвээ нэгэнт энэ хэрэгжих боломжгүй юм бол энэ тогтоолуудаа бараг хүчингүй болгох ёстой юм болов уу? Нэлээн дээр үеэс л эхэлсэн ийм тогтоолууд байгаад байх юм. Эсвэл энэ нь зөв зүйтэй тогтоол байсан юм гэж үзэх юм бол сая бас гишүүдийн өмнө гарч байна. Засгийн газрыг шахах хэрэгтэй байх. Энэ Улсын Их Хурлаас даалгавар болгож өгсөн. Энэ 5-ын 5 тогтоолоо хэрэгжүүлээч. Холбогдох хууль тогтоомжид нь өөрчлөлтөө оруулаач ээ, зааглаж ангилах ёстой бол зааглаж ангилаач ээ. Бүх юмыг энэ конвенцын өгсөн зөвлөмжийн дагуу л хийх ёстой байх. Нэгэнт элссэн бол энэ чинь Үндсэн хуульд ч хүртэл байгаа шүү дээ. Олон улсын гэрээ конвенцоо урьдчилж дагана гээд. Тэгэхээр энэнийхээ дагуу бүх хууль тогтоомжоо өөрчлөх ёстой. Тэгэхээр Засгийн газар ажлаа хийхгүй байгаа юм байна гэж би харж байна.

Тэгэхээр энэ өгсөн тогтоолын энэ дагуу Засгийн газрын ажлаа хийх хэрэгтэй. Энийг ХЗБХ шахах хэрэгтэй. Эсвэл Улсын Их Хурал маань өөрөө буруу зөрүү тогтоол гаргачихсан юм бол энэ тогтоолоо хүчингүй болгох хэрэгтэй болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Яг тэгж тусад нь гарга гэсэн тогтоол Баярмаа гишүүн ер нь гаргаж байгаагүй шүү. Тийм зөвлөмж эд нар нөгөө ОУБ-аасаа тийм юм бас яриад байдаг учраас Одонтуяа гишүүний ярьж байгаа юманд бас нэг үндэслэл байгаа юм. Түүнээс тэгж тогтоол одоохондоо гаргаж байгаагүй. Яг тэгж тусгайлан тэгж зааж барьсан юм байхгүй.

Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Уул нь энэ их чухал асуудал л даа. Тэгээд чухал ажил хийж байгаа л хүмүүс л дээ. Яг ардчилсан улс оронд энэ хүний эрхийн асуудал энэ эрүүдэн шүүлттэй холбоотойгоор нэлээн яригддаг. Энэ Монгол Улс тэр чигээрээ л эрүүдэн шүүлтэд байна л даа. Монголын ард түмэн. Өдөр болгон л авлига, хулгай, энэ их мөнгө төгрөг яваад байх юм. Бие биедээ шилжүүлсэн гээд л. Тэрэн дээр анхаарч байгаа хүн ерөөсөө алга. Яах вэ тэр ОУБ-аас тавьдаг шаардлагынхаа дагуу эрх биш нэг ардчилсан улс гэдэг нэртэй болохоороо энэ зөвлөмж энэ тэр гаргаад ном хэвлүүлээд л байдаг юм шиг байна. Энэ номоо ч хэвлүүлчихсэн л байна л даа жил болгон. Тэгээд яг та бүхэн хөрсөн дээрээ буугаач ээ, амьдрал дээр очоо ч. Одоо

байнга л цэцэрлэгт л гэхэд л хүүхдийг чинь зодож нүдээд л тамлаад л ингээд л байна шүү дээ. Тэгээд л хэн нэгэн хүн тэрийг сошиалд тавьчихаар л сошиалд тавьж байгаа үед нь л бид нар анзаарч байна. Тэрний ар талд хэчнээн юм байгааг бүү мэд. Тэгээд Улаанбаатарын тунхаглал гээд л энэ хууль хяналтын байгууллагууд нэгдэж байна гээд л янз бүрийн юм энэ дээр тавьчихсан л байна л даа. Бичиг сачиг. Тэгээд бүх нийтээр нь Улаанбаатараас ярьж байна гээд л. Ингээд бүх телевизийн сувгуудаар ингээд л эрүүгийн элементүүдийг гаргаж ирээд л, ингээд л яриулаад байдаг шүү дээ. Энэ эрүүдэн шүүлт мөн үү биш үү? Тэгж байх үед та нар хаана нь байдаг юм бэ? Энэ талбай дээр чинь тэр цаанаасаа улсын мөнгө төгрөгөөр татвар төлөгчдийн мөнгөөр мэр сэр бариулаад л жагсаад л ингээд л явдаг шүү дээ.

Зүгээр жирийн иргэн гарч ирээд жагсаж болохгүй, зөвшөөрөл өгч болохгүй, зөвшөөрөл өгдөггүй. Тэгээд ийм үед та нар хаана нь байдаг юм бэ? Жишээлбэл над дээр гэхэд нэг өргөдөл ирж байсан ШЕЗ-өөс ШЕЗ-ийн ажлын албаны дарга Э билүү хэн ч гэлээ дээ. Тэнд байгаа хүмүүс бэлгийн дарамт үзүүлээд би тэр даргаас томилогдсон хүн гээд байнга тамладаг. Зүгээр ШЕЗ, Шүүхийн сахилгын хороон дээр л тийм байна шүү дээ. Тэгээд та нар тэрэн дээр нь ямар ч арга хэмжээ авдаггүй. Тэгээд нөгөө хүмүүс нь ажлаасаа аргагүйн эрхэнд гараад явдаг. Зүгээр яар вэ тэр зөвлөмж энэ тэр гаргаад энэ ном мом хэвлүүлээд ингээд явах нэг өөр л дөө. Тэрийгээ нэг нэр төдий биш яг энд тэр эрүүдэн шүүх үйл ажиллагаанд нь орсон, тасалсан, зогсоосон энэ урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа явуул л даа та нар. Тэрний үр дүн наана чинь харагдахгүй байна шүү дээ. Зүгээр бид нар жил болгон ярьсан болдог хэлсэн болдог тэгээд л нэг өнгөрдөг ийм л болчихоод байгаа юм л даа. Жоохон ажилдаа хариуцлагатай хандмаар байна нөхдүүд ээ. Хар л даа тэгээд энэ эрүүл мэнд нийгмийн даатгал энэ идээд уугаад явчихдаг. Тэгээд өвчин зовлон болохоор энэ хүүхдүүд энэ эмнэлгийн коридороор дүүрэн тэгээд ор ч байхгүй юу ч байхгүй ингээд хэвтэж байдаг.

Энэ чинь бас л эрүүдэн шүүлтийн нэг хэлбэр шүү дээ. Тэр байтугай одоо энэ эрх барьж байгаа нам 105 жил болчихсон гэж байгаа. Тэр гучин хэдэн онд хэлмэгдүүлж байсан энгийн номхон ард иргэдийг амьдрах тийм орон зай өгөхгүй байдаг байсан. Энэнийхээ төлөө уучлалт гуйсан юм уу? Энийг та нар ерөөсөө ярьдаггүй шүү дээ.

Д.Цогтбаатар: Нэг минут гүйцэж өгье.

Д.Ганбат: Одоо Монгол Улсын иргэд энэ залуучууд маань энэ Монгол Улсдаа амьдрах ямар ч боломжгүй байна шүү дээ. Хөгшдийн тэтгэвэр амьдралд нь хүрэхгүй байна. Энэ бол бас эрүүдэн шүүлтийн нэг хэлбэр гэж бодож байна. Тэгэхэд авлига хулгай энэ бүх юм бол гаарч байна шүү дээ. Тэд нарт хууль үйлчлэхгүй байна шүү дээ энэ. Энэ дээр та бүхэн бас нэг энэ зөвлөмж энэ тэрдээ бас тусгачхаж байвал зүгээр байх аа. Энэ цагдаа цагдаагийн байгууллага бол яг л хуучин хэлбэрээрээ л ажиллаж байна шүү дээ. Тэр байнга дууддаг гаднаа тэгээд л хэдэн цагаар байлгаж байдаг. Арга ч үгүй юм даа. Энэ мөрдөн байцаалтын үйл ажиллагаа нь яг л тэр дотоод газрын хар дэглэмийн үед байж байсан тэр л арга хэлбэр.

Д.Цогтбаатар: Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Ерөнхийдөө үйл ажиллагааны тайлан дээр ингээд харж байхад гарсан гомдол хуваарьт төлөвлөгөөний дагуу илүү их очиж ажилладаг хяналт шалгалт хийж ажиллаж байна. Тэгэхээр энэ АТГ, ЦЕГ гээд энэ мөрдөн

байцаах үйл явцдаа эрүүдэн шүүлтийн үйл ажиллагаа явуулж байж болзошгүй ийм байгууллагууд дээр бас ийм статистик дата цуглуулж тэрэн дээрээ дүн шинжилгээ хийх тал дээр анхаармаар юм шиг санагдаж байгаа юм. Яагаад энэ тухай ярьж байна вэ гэхээр АТГ дээр чинь яг одоо адилхан авлигалын хэргээр мөрдөн байцаагдаж байгаа 2 хүнийг нэгийг нь болохоор гадуур байцаагаад байдаг, нөгөөдхийг нь болохоор өчнөөн сараар хориод байцаагаад байдаг гэр бүлийн гишүүдийг нь хамруулдаг ч байдаг юм уу ингээд ийм зүгээр л тэр тухайн хүний нөхцөл байдлаас хамаараад л ялгаатай хандаж байгаа ийм асуудал их харагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр АТГ болон ЦЕГ-ын мөрдөн байцаах газар дээр байцаагдаж байгаа улсууд дээр цаад талд нь тэр тухайн байцаагдаж байгаа хүн ер нь хэд хоног хоригдож байгаа, ямар асуудлаас болоод тэр асуудлаас нь болоод хэчнээн хүнийг нь бол хэчнээн хүнийг холбогдуулж хорьж байгаа юм. Энэ хугацаа нь ямар хугацаанд үргэлжилж байгаа юм. Энэ тэр гээд нэг ийм статистик мэдээлэл цуглуулаад тэрэн дээрээ илүү дүн шинжилгээ хийгээд яг нэг тухайн гомдол дээр ажиллах биш нэг нийт ерөнхий трендээр нь хардаг нэг тиймэрхүү ажлууд хийвэл яадаг юм бол гэсэн нэг ийм надад нэг санал байна. Тэгэхээр энэ дээрээ бас цаашдаа анхаарч ажиллавал зүгээр байх гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Би нэг 2, 3 үг хэлчихье. Цэлмэн дарга аа энэ Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүндэтгэлтэй хандана аа. Таныг наад албан дээрээ очоогүй байхад чинь энд сууж байгаа зөндөө олон хүмүүс хүний эрхийн тухай ярьж, наад хүний эрхийн комисст чинь хуулийн сайжруулах хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулахын төлөө хүмүүст сайн муу хэлүүлж байгаад яриад явж байсан хүмүүс энд сууж байна аа. Энэ хүний эрхийн асуудлыг өнөөдөр ингэж ярьдаг шиг ярьдаггүй байсан юм. Ерөөсөө хэдхэн жилийн өмнө шүү. Тэгэхээр та нарын баталсан хуулиар л бид нар явж байна гээд. Энд сууж байгаа нэг ч хүн төгс төгөлдөр хууль баталчихдаг. Тийм бурхан шиг хүмүүс байхгүй. Амьдрал дээр хууль хэрэгжээд ирэхлээрээ дутагдал юм нь гарах тохиолдол зөндөө байдаг.

Тийм учраас хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах механизм хуульд нь өөрт нь сууж өгсөн байдаг. Хууль өөрөө хүлээн зөвшөөрч байгаа байхгүй юу. Хүн л баталж байгаа юм болохоор бас амьдрал дээр гарч ирээд туршигдаад ирэхлээрээ, хэрэглэгдээд ирэхлээрээ дутуу юм гарч болно оо тэрийг сайжруулж болно оо гэж байгаа юм. Түүнээс угаас төгс юм гаргадаг бол хуульд нэмэлт, өөрчлөлтийн тухай заалт ч байгаад хэрэггүй шүү дээ.

Тэгэхээр энд байгаа гишүүдийг тэгж хандаж тийм өнгө аясаар та ярих юм бол одоо яг өөрийн чинь ярьж байгаа тэр олон улсын конвенцынхаа зарчмыг бариад л та ярьдаг энэ асуудал чинь явахгүй шүү дээ. Энд тэгээд энэ гишүүдийн ярьж байгаа асуудлуудад үнэхээр анхааралтай хандах ёстой. Танай наана чинь байгаа асуудал бол бас яг үнэнийг хэлэхэд танай дотоод албан тушаал сандал суудлын хэрүүлээс л үүдэлтэй юм шүү дээ. Тэгээд л тэндээсээ болоод л сүүлдээ энэ нь таарах таарахгүй болоод явчихсан. Та нарын энэ таарах таарахгүйгээс болоод Монгол Улсад иргэдийн эрхээ хамгаалуулах тэр эрх ашиг харин хөндөгдөж болохгүй шүү дээ.

Тийм учраас энд саяын гишүүдийн ярьж байгаа олон юмнуудыг та анхаарч цаашдаа ажиллах ёстой. Ямар нэгэн гаднын нөлөөнд би уг нь түрүүн асуулт асууя гэж бодож байсан тэгээд өнгөрүүлчихлээ. Хэн нэгний дарамт шахалт гаднын

нөлөөнд ялангуяа ийм асуудал ярьж байхад наадах чинь өөрөө хэцүү, дандаа нөгөө төрийн асуудал байдаг. Одоо энэ гишүүд ч ярьж байна шүү дээ. Аливаа нэгэн эрүүдэн шүүлттэй холбоотой асуудал бол эргээд эрх мэдэлтнүүдийн л тухай асуудал байдаг. Эрх мэдэлтэнтэй харилцаа холбоотой энд тэнд татлаа түтлээтэй хүмүүстэй л холбоотой асуудал гарч ирж байдаг учраас наадах дээр чинь тэр тавих хяналт үнэхээр хараат бус байх ёстой.

Тэгээд энэ дээрээ бол та нар илүү зоригтой, зүрхтэй, үгээ хэлж ажиллах ёстой. Тэгээд энэ дээрээ илүү үр дүнтэй, үр дүн хаана байна вэ гээд энэ асуугаад байгаа чинь бас асуух ёстой асуулт шүү. Тэгэхээр тэр асуудлуудаа нэлээн анхаарч ажиллах ёстой. Би түрүүн хэллээ энэ сургуулийн хүүхдийн дээрэлхлийн тухай асуудал та нарын харааны гадна үлдэж болохгүй. Яг автоматаар би түрүүн эрх зүйн үндэслэлийг нь гаргаж өглөө шүү дээ. Та түрүүн өөрөө хариулахдаа энэ сургууль ээж, аав хүүхдийн асуудал. Бид нар бүүр анхаарахгүй байгаа биш анхаарч байгаа гээд. Би танд эрх зүйн гаргалгааг нь гаргаж өгч байна шүү дээ. Насанд хүрээгүй хүүхдүүд бол өөрсдөө эрүүгийн хуулиар ямар нэгэн хариуцлага хүлээх боломжгүй субъектүүд. Тэгэхдээ тэр чинь эрүүгийн хариуцлага тэгэхээр энэ нийгэмд тэрэнтэй холбоотой аливаа зөрчил гарахад байхгүй гэсэн үг биш шүү дээ.

Хуулийн хүрээнд тэрийг хүлээдэг субъектүүд байдаг. Тэр нь нөгөө насанд хүрэгчид, эцэг эх, төр, энэ хууль журмыг гаргаж байгаа хүмүүс байхгүй юу. Тэр хүмүүсийг хариуцлагаа хүлээдэг насандаа хүртэл тэр хариуцлагыг нь өмнөөс нь нийгэм өөрөө төр өөрөө хүлээж байгаа юм. Тэр утгаараа энийг цаашаа өөгшүүлээд явж байгаа бол шууд энэ төрийн үйл ажиллагаатай эс үйлдэлтэй холбоотой гэх юм бол наадах чинь танай конвенцын риздикцэд ороод ирнэ гэсэн үг. Тэгээд аль болох ингээд бултаад нэг жоохон зөвлөмж өглөө гээд сууж байх биш. Наадхыгаа уг юугаар нь углуургаар нь харж зөвлөмждөө бас энэн дээр төр ингэж анхаарах ёстой. Тэр хариуцлага хүлээх эцэг эхтэй нь, сургуультай нь, цагдаатай ийм хариуцлага тооцож байх ёстой. Сургалт компани ажил явуулж уу үгүй юу гээд. Энэн дээр та нар анхаарах ёстой байхгүй юу. Түүнээс конвенцоо зүгээр яг үг үсгээр нь хараад энэ манайд хамаагүй юм байна гээд бултах гээд ч юм уу өөрсдөөсөө нэг метр зайлуулах гээд сууж байж болохгүй шүү.

Энийг бол харж анхаарч ажиллах ёстой. Сенсацаар ажиллахгүй ээ. Одоо танайтай холбогдсон юмнуудыг би ингээд харж байхад ганц 2 юман дээр бас сенсацын шинж чанартай мэдээ эд нар гарсан юм байна лээ шүү. Та тэрийгээ бас ажил дээрээ анхаараарай. Би бол та нарыг ажил дээр чинь дэмжиж ажилладаг. Тэгэхдээ шударгаар бас энэ гарч байгаа дутагдлуудыг би хэлнэ ээ.

Тэгэхээр сенсацаар ажиллах юм бол хүний эрхийн нөхцөл байдал харин дордоно шүү. Та нар сенсац руу орчих юм бол та нар ямар ч сенсацгүй, та нар факт дээр, хууль дээр л ажилладаг байх ёстой. Тэгээд энэн дээрээ анхаарч ажиллаарай.

Дараагийн удаа тайлангаа харин хийхдээ Хялбаршуулсан саммори маягаар одоо энэ гишүүд та нар 7 хоногийн өмнө л нэрээ өгчихлөөр би гишүүдэд хэчнээн тараагаад ч бас бүгдийг нь уншиж амжихгүй нөхцөлүүд бий.

Тийм учраас нөгөө экзектив саммори гээд их товчхон юу байдаг тийм юугаар ч гэсэн хийгээд гишүүдэд тараачхаж байх хэрэгтэй. Хүн болгон эрх зүйн чиглэлээр бэлтгэгдсэн биш байдаг учраас тэрийг чинь тэгвэл их энгийн ойлгомжтойгоор хэн ч уншаад ойлгогдохуйц хийдэг байх ёстой. Наадах чинь л төрд нөгөө мэдээллээ зөв

хүргэж ажиллаж байна гэсэн үг. Тэрэн дээр бас сэтгэлээ гаргаж оюун ухаанаа уралдуулж ажиллаж байх ёстой шүү. Ингээд миний зүгээс хэлэх зүйл ийм байна.

Ингээд юу гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Мөн түүнчлэн гишүүд энэ тайлантай холбогдуулан үг хэлж дууслаа. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны тайланг хэлэлцэж дууслаа. Ингээд хурал хаахаасаа өмнө би нэг товчхон нэг зүйл хэлчихмээр байна.

Энэ маргааш уг нь нөгөө Улсын дээд шүүх дээр хэлэлцүүлэгтэй байсан юм манай Байнгын хорооныхон. Энэ өнөөдрийн энэ нөхцөл байдал юмтай холбогдуулаад хойшилж байгаа. Энийг тэгээд дараа нь жич бид нар цаг зарлаж байгаад хийе. Өнөөдөр 14 цагаас Тэмүүжин гишүүний энэ ахалж байгаа ажлын хэсгээс энэ худал мэдээлэл тараахтай холбогдсон энэ Эрүүгийн хуулийн талаарх хэлэлцүүлэгт манай гишүүд идэвхтэй оролцоод өгөөрэй. Тэгээд энд бас өөрсдөө бас мэдээллээ аваад дараа дараагийн хэлэлцүүлэгт энд та бүгдийн өөрсдийн чинь ажилд хэрэг болно шүү.

Ингээд хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөлөө. Гишүүддээ талархал илэрхийлье ээ.

12.25 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА